



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Улаанбаатар хот

2019 оны 6 дугаар сар



Тайланг бэлтгэсэн:

**Үндэсний аудитын газрын
Санхүүгийн аудитын газар**

**Газрын захирал бөгөөд
тэргүүлэх аудитор**

Ц.Наранчимэг

Аудитын менежер

С.Оюунгэрэл

Ахлах аудитор

**Д.Цэрэндорж
Ш.Ичинхорлоо**

Аудитор

**О.Баярмаа
Ж.Болормаа
Л.Мөнхцацрал
С.Отгонхорлоо
Д.Цэгмиддорж
Ц.Энхжаргал
Б.Энхжин
Б.Эрдэнэзул**

Агуулга

Товчилсон үгийн жагсаалт	1
Нэг. Ерөнхий зүйл	2
ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ	3
БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ	4
БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ	6
2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж	6
2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл	9
2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл	12
2.4 Монгол Улсын Засгийн газрын өр	12
БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСӨВ	16
3.1 Улсын төсвийн орлого	16
3.2 Улсын төсвийн зарлага	18
3.3 Улсын төсвийн тэнцэл	20
БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ	22
4.1 Орон нутгийн төсвийн орлого	22
4.2 Орон нутгийн төсвийн зарлага	22
4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл	24
БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ	25
5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого	25
5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага	25
5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	25
БҮЛЭГ 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ	26
6.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн орлого	26
6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага	26
6.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл	27
БҮЛЭГ 7. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	28
Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар	28
Д Ү Г Н Э Л Т	29
Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:	30
З Ө В Л Ө М Ж	30
Хавсралтууд	31
Монгол Улсын Ерөнхий аудиторын тушаал	34

2019 оны 6 дугаар сар

**Уг тайланг УАГ-ын
цахим хуудаснаас үзнэ үү:**

www.audit.mn

**Аудитын тайлантай
холбоотой асуудлаар нэмж
тодруулах зүйлийн талаар
261663 дугаарын утсаар
харилцана уу.**

ХАЯГ:

**Үндэсний аудитын газар
Чингэлтэй дүүрэг,
Засгийн газрын 4 дүгээр
байр, Бага тойруу-3
Улаанбаатар-15160
Монгол Улс**



Товчилсон үгийн жагсаалт

ААНБ	Аж ахуйн нэгж, байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
Ам.доллар	Америк доллар
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
АХБ	Азийн хөгжлийн банк
БНСУ	Бүгд Найрамдах Солонгос Улс
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БСШУСС	Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайд
БХБС	Барилга, хот байгуулалтын сайд
БХС	Батлан хамгаалахын сайд
ГХС	Гадаад харилцааны сайд
ДНБ	Дотоодын нийт бүтээгдэхүүн
ДЦС	Дулааны цахилгаан станц
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
ЗТХС	Зам, тээврийн хөгжлийн сайд
ЖДҮХС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МХС	Мал хамгаалах сан
МИАТ	Монголын иргэний агаарын тээвэр
НББСШУ	Нийгмийн бодлого, Боловсрол, Соёл, Шинжлэх ухаан
НДС	Нийгмийн даатгалын сан
НЗДТГ	Нийслэлийн Засаг даргын Тамгын газар
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
мян.тн	мянган тонн
ОАТ	Онцгой албан татвар
ОБЕГ	Онцгой байдлын ерөнхий газар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОУВС	Олон улсын валютын сан
ӨҮЦ	Өнөөгийн үнэ цэнэ
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
СХС	Сум хөгжүүлэх сан
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЗШ	Тусгай зориулалтын шилжүүлэг
ТӨХК	Төрийн өмчит хувьцаат компани
ТХМ	Төсвийн хүрээний мэдэгдэл
ТЭДС	Тариалан эрхлэлтийг дэмжих сан
тн	тонн
УИХ	Улсын Их Хурал
ҮОМШӨ	Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин
ХАА	Хөдөө аж ахуй
ХЗДХС	Хууль зүй, дотоод хэргийн сайд
ХК	Хувьцаат компани
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд
ХХААХҮС	Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ШЕЗ	Шүүхийн ерөнхий зөвлөл
ЭАХБ	Эрхлэх асуудлын хүрээний байгууллага
ЭМДЕГ	Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газар
ЭМДҮЗ	Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл
ЭМДС	Эрүүл мэндийн даатгалын сан
ЭХС	Эрчим хүчний сайд



Нэг. Ерөнхий зүйл

Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй

Үндэсний аудитын газар Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.7-д заасан бүрэн эрхийн хүрээнд Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2¹ дахь заалтын дагуу Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд 2019 оны 5 дугаар сарын 13-ны өдрөөс 6 дугаар сарын 10-ны өдөр хүртэлх хугацаанд аудит хийв.

Аудитын зорилт

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл үнэн зөв илэрхийлэгдсэн эсэх талаар үндэслэлтэй баталгаагаар хууль тогтоох байгууллагыг хангахад энэхүү аудитын зорилт чиглэгдлээ.

Хамарсан хүрээ

Сангийн яам Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.7²-д заасны дагуу Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан, танилцуулгыг дараах бүрэлдэхүүн хэсэг, дараалалтай тайлагнажээ. Үүнд:

- Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл
- Монгол Улсын 2018 оны төсвийн гүйцэтгэл
- Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэл
- Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн гүйцэтгэл
- Орон нутгийн төсвийн 2018 оны гүйцэтгэл
- Монгол Улсын Засгийн газрын өрийн талаарх танилцуулга

Танилцуулгын хавсралт мэдээлэл:

- Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн үр дүнгийн үзүүлэлт
- Улсын ТЕЗ-дын 2018 оны төсвийн гүйцэтгэл
- Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээний гүйцэтгэл
- Засгийн газрын нөөц сангийн гүйцэтгэл
- НДС, ЭМДС, Орон нутгийн төсвийн гүйцэтгэл
- Засгийн газрын өрийн үзүүлэлтүүд, гадаад зээлээр хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр
- Худалдан авах ажиллагааны тайлан
- Татварын зарлагын тайлан
- 2018 оны нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан
- ТЕЗ-дын 2018 онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийн тайлангийн нэгтгэлийг тус тус толилуулсан байна.

Арга зүй, стандартын талаарх мэдэгдэл

Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт, Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын арга зүй, журмыг баримтлан Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн баталсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу аудитыг гүйцэтгэсэн бөгөөд Сангийн яам болон бусад холбогдох яам, байгууллагын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, судалгаа авах, дансны хуулгатай тулган баталгаажуулах, тоон мэдээлэл авах, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг хэрэгжүүлж, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмжийг боловсруулав.

Аудитын тайланд орон нутгийн төсвийн гүйцэтгэлд нэгдсэн удирдамжаар хийсэн аудитын дүнг нэгтгэсэн бөгөөд улсын төсвийн хөрөнгө оруулалтын гүйцэтгэлд тусад нь аудит хийсэн тул уг тайланд оруулаагүй болно. Аудитын нотлох зүйлс, холбогдох мэдээ судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

¹ "төрийн аудитын төв байгууллага нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланд нэг сарын дотор аудит хийж, Засгийн газар, Улсын Их Хуралд хүргүүлэх"

² "нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан гаргах"



ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлийн танилцуулгад дурдсан эдийн засгийн макро түвшний үзүүлэлтүүдийг Үндэсний Статистикийн хорооноос гаргасан 2018 оны урьдчилсан гүйцэтгэл болон Монголбанкны 2018 оны жилийн тайлангаас дэлгэрүүлэн авч үзсэн болно.

ДНБ-ийн урьдчилсан гүйцэтгэлээр Монгол Улсын эдийн засгийн бодит өсөлт 2018 онд 6.9 хувьд хүрч, төлөвлөсөн зорилтот түвшнээс 2.7 нэгж хувиар өссөн байна.

Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуй, боловсруулах үйлдвэрлэл, үйлчилгээ, санхүү, даатгалын үйл ажиллагааны салбар өсөлттэй байсан нь голлон нөлөөлжээ.

Төлбөрийн тэнцлийн статистикаар нийт тэнцэл өмнөх онд 1,459.9 сая ам.долларын ашигтай байснаас тайлант онд урсгал дансны алдагдал нэмэгдсэнээр нийт тэнцэл 1,601.6 сая ам.доллараар буурч, 141.7 сая ам.долларын алдагдалтай гарсан байна.

Гадаад худалдааны тэнцэл 1,136.8 сая ам.долларын ашигтай гарч өмнөх оноос 726.5 сая ам.доллараар буюу 39.0 хувиар буурсан нь экспорт 13.1 хувь, импорт 35.5 хувиар өссөн буюу импортын өсөлт экспортын өсөлтөөс түрүүлснээс шалтгаалжээ.

Хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцийн түвшин 2018 оны 12 дугаар сарын байдлаар улсын хэмжээнд 8.1 хувьтай гарч, Монголбанкны зорилтот түвшнээс 0.1 нэгж хувиар нэмэгдсэн байна.

Гадаад валютын улсын нөөцийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Монголбанк 2018 онд нийт 22 тонн үнэт металлыг худалдан авч, нөөцийг 740.0 сая ам.доллараар нэмэгдүүлснээр оны эцэст гадаад валютын албан нөөц 3,549.1 сая ам.долларт хүрч, өмнөх оноос 18.0 хувиар буюу 541.0 сая ам.доллараар өсчээ.

Тайлант оны эхэнд мөнгөний бодлогын хүү 11.0 хувь байсныг Монголбанкны Мөнгөний бодлогын зөвлөлийн 2018 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн шийдвэрээр 10.0 хувиар тогтоон мөрдсөн бөгөөд оны эцэст буюу 2018 оны 11 дүгээр сарын 28-нд 11.0 хувиар шинэчлэн тогтоосон байна.

Эрдэс баялгийн голлох нэрийн бүтээгдэхүүний үнийн өсөлт, хөрш орны зах зээлийн эерэг хандлага зэрэг гадаад хүчин зүйлсээс гадна ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр” үргэлжилсэн, валютын нөөц нэмэгдсэн, эдийн засгийн идэвхжил сэргэж, бодит эдийн засаг өссөн зэрэг дотоод хүчин зүйлсийн нөлөөллийн орчинд Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсөв хэрэгжсэн байна.



БҮЛЭГ 1. ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ

1.1 Монгол Улсын тухайн жилийн нэгдсэн төсвийн төслийг боловсруулах, батлах харилцааг Төсвийн тогтвортой байдлын тухай болон Төсвийн тухай хуулиар зохицуулдаг.

1.2 Улсын Их Хурлаас Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2019-2020 оны төсвийн төсөөллийн тухай хуулийг анх 2017 оны 5 дугаар сарын 31-нд баталсан бөгөөд түүнд 2017 оны 11 дүгээр сарын 14-нд нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Хүснэгт 1 Төсвийн хүрээний мэдэгдлийн өөрчлөлт

Д/д	Эдийн засгийн үндсэн үзүүлэлт	Төсвийн хүрээний мэдэгдэл		Өөрчлөлт	
		2017.05.31	2017.11.14	Хувь	Зөрүү
1	Дотоодын нийт бүтээгдэхүүний бодит өсөлтийн хэмжээ /хувь/	1.8	4.2	233.3	2.4
2	Хэрэглээний үнийн өсөлтийн түвшин	6.1	8.6	141.0	2.5
3	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогын хэмжээ /тэрбум төгрөг/	6,808.4	7,231.4	106.2	423.0
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	24.6	23.8	96.7	-0.8
4	Нэгдсэн төсвийн нийт зарлагын дээд хэмжээ /тэрбум төгрөг/	9,451.0	9,651.5	102.1	200.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	34.1	31.8	93.3	-2.3
5	Нэгдсэн төсвийн нийт зарлагын өсөлтийн хэмжээ /тэрбум төгрөг/	700.8	497.0	70.9	-203.8
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	2.5	1.6	64.0	-0.9
6	Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл /тэрбум төгрөг/	-2,642.6	-2,420.1	91.6	222.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	-9.5	-8.0	84.2	1.5
7	Нэгдсэн төсвийн хөрөнгийн зардлын хэмжээ /тэрбум төгрөг/	1,623.0	1,928.5	118.8	305.5
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	5.9	6.3	106.8	0.4
8	Засгийн газрын өрийн нийт хэмжээ, өнөөгийн үнэ цэнээр /тэрбум төгрөг/	22,155.2	24,309.6	109.7	2,154.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	80.0	80.0	100.0	0.0
9	Нийгмийн халамжийн тухай хуульд заасны дагуу төсвөөс санхүүжүүлэх зардлын нийт хэмжээ /тэрбум төгрөг/	499.6	646.0	129.3	146.4
	-Дотоодын нийт бүтээгдэхүүнд эзлэх хувь	1.8	2.1	116.7	0.3

1.3 Хүснэгтээс үзвэл, Анх баталснаас 5 сар гаруй хугацааны дараа баталсан Төсвийн хүрээний мэдэгдэлд Засгийн газрын өрийн ДНБ-д эзлэх хувиас бусад бүх үзүүлэлтэд өөрчлөлт оруулсан байна. Тухайлбал,

- ӨҮЦ-ээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн хэмжээг 2,154.4 тэрбум, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлогыг 423.0 тэрбум, нийт зарлагыг 200.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэх, нэгдсэн төсвийн тэнцлийн алдагдлыг 222.5 тэрбум төгрөгөөр бууруулах;
- Зарлагын бүтцэд өөрчлөлт хийж, хөрөнгийн зардлыг 305.5 тэрбум, нийгмийн халамжийн зардлыг 146.4 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэхээр тооцжээ.

1.4 Энэ нь Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.3-т “Төсвийн төсөл боловсруулах, батлах, ... дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлнэ” гэж заасантай нийцэхгүй, ТХМ-д тусгах эдийн засгийн үндсэн үзүүлэлтүүдийг бодитой тооцож батлуулан төсвийн төлөвлөлтөд баримтлах талаар Үндэсний аудитын газраас өмнөх онд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

1.5 ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд төсвийг тогтворжуулах чиг хандлага үргэлжилж, улсын төсөвт тодотгол хийгээгүй боловч зарим аймаг, орон нутаг оны эцсийн төсвийн зарцуулагдаагүй үлдэгдлээс санхүүжүүлэх зардлыг төсөвт тусгах байдлаар орон нутгийн төсвийг өөрчилсөн байна.



1.6 Иймд макро эдийн засгийн дунд хугацааны төсөөлөл, гадаад, дотоод хүчин зүйлсийг үндэслэлтэй тооцоолж, ТХМ-ийг боловсруулж батлуулах, батлагдсан хууль, суурь тооцооллыг өөрчлөх бус тууштай баримтлан бүх шатны төсвийн төслийг боловсруулан баталж, Төсвийн тогтвортой байдлын шалгуурыг хангах шаардлагатай байна.

1.7 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн бүрэлдэхүүн төсөв хоорондын орлого, зарлагын шилжүүлгийг 2,760.6 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр гарсан 2,753.7³ тэрбум төгрөгийн гүйлгээг цэвэрлэн тайлагнажээ.

³ Орон нутгаас улсын төсөвт төвлөрүүлэх шилжүүлгийг 289.2 тэрбум төгрөгөөр төлөвлөж, төвлөрүүлсэн; Улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгосон тусгай зориулалтын болон ОНХНС-ийн шилжүүлэг, санхүүгийн дэмжлэгийг нийт 1,388.4 тэрбум төгрөгөөр төлөвлөж, санхүүжүүлсэн; ЭМД-ын сангаас улсын эмнэлгүүдэд олгосон татаас 214.5 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 213.3 тэрбум, НДШ-ийн зардал 258.7 тэрбум төгрөгөөр төлөвлөгдөж, 253.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэл тус тус гарсан бол, Улсын төсвөөс НДС-д олгох татаасыг 609.8 тэрбум төгрөгөөр төлөвлөж, бүрэн санхүүжүүлсэн байна.



БҮЛЭГ 2. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСӨВ

2.1 Нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламж

2.1.1 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн хэмжээг 8,036.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс гүйцэтгэлээр 10,172.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөгөө 2,136.6 тэрбум төгрөг буюу 26.6 хувиар, өмнөх оны мөн үеэс 2,214.5 тэрбум төгрөг буюу 27.9 хувиар тус тус давж биелсэн байна.

Хүснэгт 2 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн орлогын эдийн засгийн ангилал (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	Өмнөх оны гүйцэт	2018 он				Өмнөх оноос	
		Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү	Хувь	Зөрүү
Нийт тусламжийн орлого ба тусламжийн дүн	7,958.3	8,036.2	10,172.8	126.6	2,136.6	127.9	2,214.5
Тогтворжуулалтын сан	325.7	122.8	207.0	168.7	84.2	63.6	(118.7)
Ирээдүйн өв сан	357.7	508.7	620.7	122.0	112.0	173.5	263.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	7,274.9	7,404.7	9,345.1	126.2	1,940.4	128.5	2,070.2
Татварын орлого	6,315.2	6,356.9	8,227.8	129.4	1,870.9	130.3	1,912.6
Татварын бус орлого	959.7	1,047.8	1,117.3	106.6	69.5	116.4	157.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.1.2 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт орлого 10,172.8 тэрбум төгрөгт хүрч, Тогтворжуулалтын санд 207.0 тэрбум төгрөг, Ирээдүйн өв санд 620.7 тэрбум төгрөгийг тус тус хуваарилсан байна.

2.1.3 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого 9,345.1 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 26.2 хувиар буюу 1,940.4 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 2,070.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.1.4 Төсвийн тогтвортой байдлын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4-т заасан зарчмын дагуу 2018 онд 1 тн зэсийн тэнцвэржүүлсэн үнийг 5,106.9 ам.доллараар тооцсон ба зэсийн зах зээлийн үнэ жилийн турш тооцсон үнээс дээш байсан нь Төсвийн тогтворжуулалтын санд 207.0 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэх нөхцөлийг бүрдүүлжээ.

2.1.5 Ирээдүйн өв сангийн тухай хуулийн дагуу 2018 онд тус санд 508.7 тэрбум төгрөг төвлөрүүлэхээр батлагдсанаас 620.7 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 112.0 тэрбум төгрөг буюу 22.0 хувиар давж биелсэн нь өмнөх оноос 263.0 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн байна.

2.1.6 Монгол Улсын нэгдсэн төсвийн орлогын гүйцэтгэлийг төсөв тус бүрээр нь авч үзвэл, төлөвлөсөн дүнгээс Улсын төсвийн орлогын гүйцэтгэл 31.1 хувь буюу 1,817.3 тэрбум, орон нутгийн төсвийн орлогын гүйцэтгэл 3.7 хувь буюу 98.6 тэрбум, НДС-ийн орлогын гүйцэтгэл 9.4 хувь буюу 178.9 тэрбум, ЭМДС-ийн орлогын гүйцэтгэл 9.3 хувь буюу 35.1 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Хүснэгт 3 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн орлогын бүтэц (тэрбум төгрөг)

№	Үзүүлэлт	2017 оны гүйцэт	2018 оны			
			Төлөв	Гүйцэт	хувь	Зөрүү
1	Монгол Улсын нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүн*	7,958.3	8,036.2	10,172.8	126.6	2,136.6
2	Улсын төсвийн орлого	5,857.1	5,838.8	7,656.1	131.1	1,817.3
3	Орон нутгийн төсвийн орлого	2,437.2	2,670.7	2,769.3	103.7	98.6
4	НДС-ийн төсвийн орлого	2,114.2	1,911.2	2,090.1	109.4	178.9
5	ЭМДС-ийн орлого	0.0	376.0	411.1	109.3	35.1


Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

/*Цэвэр дүнгээр/

2.1.7 Нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлогын 88.0 хувийг татварын, 12.0 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн бөгөөд ДНБ-д эзлэх татварын орлогын хувь болон эдийн засаг дахь татварын ачааллыг сүүлийн 5 жилээр харуулбал:



Дүрслэл 1



2.1.8 Дүрслэлээс үзвэл, 2018 онд ДНБ-ий хэмжээ өмнөх оноос 6.9 хувиар өсч, харин ДНБ-д эзлэх татварын ачаалал 25.7 хувьтай байгаа нь өмнөх оноос 2.9 нэгж хувиар өссөн байна.

2.1.9 Татварын орлого 2018 онд 8,227.8 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 29.4 хувь буюу 1,870.9 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 1,912.6 тэрбум төгрөгөөр илүү байна.

2.1.10 Нэгдсэн төсвийн татварын орлогын өсөлтөд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд,

- Эдийн засгийн өсөлт 6.9 хувьд хүрч төлөвлөсөн хэмжээнээс 2.7 нэгж хувиар нэмэгдсэн;
- Уул уурхайн голлох эрдэст бүтээгдэхүүн зэсийн баяжмалын экспорт 1,436.7 мянган тн-д хүрсэн, жилийн дундаж үнэ тн тутамд 6,524.8 ам.доллар байсан, нүүрсний экспорт 36.2 сая тн-д хүрч төсөөлсөн хэмжээнээс 8.3 сая тн-оор буюу 30.0 хувиар, нүүрсний үнэ дунджаар 44.0 хувиар тус тус өсч, төсвийн орлогод уул уурхайн салбарын нийт орлогын эзлэх хувь өмнөх оноос 7.0 нэгж хувиар нэмэгдсэн;
- НӨАТ-ын урамшууллын системийн хамрах хүрээг нэмэгдүүлж, татварын бүртгэл мэдээллийг сайжруулж, татварын суурийг өргөжүүлснээр уг системд бүртгэгдсэн цахим төлбөрийн баримтын тоо 289.2 саяд хүрч, өмнөх оноос 1.7 дахин нэмэгдсэн;
- Нийт бараа эргэлтийн хэмжээ өмнөх оноос 2.3 тэрбум ам.доллар буюу 23.6 хувиар, үүнээс экспорт 0.8 тэрбум ам.доллар буюу 13.4 хувиар, импорт 1.5 тэрбум ам.доллар буюу 35.5 хувиар тус тус өссөн;
- 2018 онд татварын байгууллагаас татварын өр барагдуулах ажлыг эрчимжүүлж, ААНОАТ-ын дутуу төлөлт 166.0 тэрбум төгрөгийг барагдуулсан зэргээр эдийн засгийн эерэг үзүүлэлтүүд голлон нөлөөлжээ.

2.1.11 Зарим гол нэр төрлийн татварын орлогыг эдийн засгийн тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх оны гүйцэтгэлээс доогуур төлөвлөсөн нь дараах орлого өндөр дүнгээр давж биелэхэд тодорхой хэмжээгээр нөлөөлсөн байна. Тухайлбал,

- Орлогын албан татварыг өмнөх оны гүйцэтгэлээс 164.1 тэрбум төгрөгөөр доогуур төлөвлөснөөс 44.3 хувиар буюу 642.0 тэрбум, өмнөх оноос 477.9 тэрбум төгрөгөөр;
- НӨАТ-ыг өмнөх оны гүйцэтгэлээс 101.2 тэрбум төгрөгөөр доогуур төлөвлөснөөс 44.7 хувиар буюу 678.6 тэрбум, өмнөх оноос 577.4 тэрбум төгрөгөөр тус тус илүү байна.

2.1.12 Татварын орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давж биелсэн боловч зарим нэр төрлийн орлого дутуу биелжээ. Үүнд,

- Автобензин, дизель түлшний ОАТ 81.9 тэрбум, дотоодын тамхины ОАТ 7.2 тэрбум,
- Улсын тэмдэгтийн хураамж 11.9 тэрбум, газрын төлбөр 2.0 тэрбум, байгалийн нөөц ашигласны төлбөр 1.4 тэрбум, бусад татвар 0.8 тэрбум, хог хаягдлын үйлчилгээний хураамж 0.2 тэрбум төгрөгөөр тус тус дутуу гүйцэтгэлтэй байна.

2.1.13 Дээрх үзүүлэлтэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд,

- Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор октаны хэмжээ 95-аас доош автобензины ОАТ-ын тн тутамд ногдуулах хувь хэмжээг тэглэсэн,
- Дорнод аймгийн ИТХ-ын 2018 оны 65 дугаар тогтоолоор Матад сумын нутаг дахь Тамсагийн сав газраас Бичигт боомт чиглэлийн газрын тосны тээвэрлэлт нь малчид, иргэдийн эрүүл мэндэд сөргөөр нөлөөлж малын бэлчээр, газрын хөрсийг муутгаж байгаагаас шалтгаалан газрын тос тээвэрлэхийг 1 сар гаруй хугацаагаар зогсоосон,
- Монгол Улсын 2018 оны төсвийг боловсруулахад улсын тэмдэгтийн болон хог хаягдлын хураамжийн орлогын Сангийн яамнаас хянасан дүнг зарим орон нутгийн ИТХ-аас нэмж баталсан.

2.1.14 Төсвийн орлогын төлөвлөгөөнд зэс, алт, коксжих болон боловсруулсан чулуун нүүрс, цайрын тэнцвэржүүлсэн үнэ, биет хэмжээг хүснэгтэд үзүүлснээр тооцож, уул уурхайн бүтээгдэхүүний борлуулалтаас орох татварын нийт орлогыг 1,720.0 тэрбум төгрөг байхаар төлөвлөснөөс, гүйцэтгэлээр 2,394.0 тэрбум төгрөгийг төвлөрүүлсэн нь нэгдсэн төсвийн нийт орлого ба тусламжийн дүнгийн 23.5 хувийг эзэлж байна.



Хүснэгт 4 Уул уурхайн бүтээгдэхүүний биет хэмжээ, тэнцвэржүүлсэн үнэ, нийт орлого

№	Бүтээгдэхүүн нэр төрөл	Биет хэмжээ			Үнэ, ам.доллар/нэгж			Нийт орлого /тэрбум төгрөг/		
		2017 гүйцэт	2018 он		2017 гүйцэт	2018 он		2017 гүйцэт	2018 он	
			Төлөв	Гүйцэт		Төлөв	Гүйцэт		Төлөв	Гүйцэт
1	Алт /тн/	17.5	21.0	18.1	1,257.2	1,291.0	1,266.5	49.1	80.4	80.0
2	Нүүрс /мян.тн/	33,400.5	28,000.0	36,265.1	68.4	53.7	77.3	692.9	495.5	998.0
3	Зэсийн баяжмал /мян.тн/	1,447.2	1,366.0	1,436.7	6,162.3	6,430.0	6,524.8	903.1	1,007.1	999.0
4	Цайр /мян.тн/	118.2	106.6	123.9	1,529.4	2,241.8	1,596.3	64.2	42.6	78.0
5	Төмрийн хүдэр /мян.тн/	6,257.8	7,500.0	7,449.0		57.0	45.9	23.4	56.5	30.6
6	Бусад							178.7	37.9	208.4
	Нийт дүн							1,911.4	1,720.0	2,394.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.1.15 Хүснэгтээс үзвэл, Уул уурхайн салбараас 2018 онд төвлөрүүлсэн орлогын 83.4 хувийг зэс, нүүрсний борлуулалтад ногдуулсан татварын орлого эзэлж байгаа бөгөөд салбарын нийт орлогын 41.7 хувийг зэсийн баяжмал, 41.7 хувийг нүүрс, 16.6 хувийг уул уурхайн бусад бүтээгдэхүүний орлогоос тус тус бүрдүүлсэн байна.

2.1.16 Уул уурхайн салбараас 2018 онд АМНАТ, ӨСНАТ-ын орлого 1,047.0 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 29.8 хувиар буюу 240.6 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Үүний 46.5 хувийг зэсийн баяжмал, 42.4 хувийг нүүрс, 11.1 хувийг уул уурхайн бусад бүтээгдэхүүний орлого эзэлж байна.

2.1.17 АМНАТ-ийн орлогоос 2018 онд Тогтворжуулалтын санд 137.7 тэрбум, Ирээдүйн өв санд 588.6 тэрбум, улсын төсөвт 320.7 тэрбум төгрөгийг тус тус төвлөрүүлсэн байна.

Хүснэгт 5 АМНАТ, ӨСНАТ-ын орлого (тэрбум төгрөг)

2.1.18 Уул уурхайн голлох эрдэст бүтээгдэхүүн нүүрс, зэсийн салбарын АМНАТ өмнөх оноос 199.3 тэрбум төгрөгөөр өссөн бол АМНАТ-аас Тогтворжуулалтын санд төвлөрүүлсэн орлого 159.7 тэрбум төгрөгөөр буурсан байна.

№	Бүтээгдэхүүний нэр төрөл	2017 гүйцэт	2018 оны	
			Төлөв	Гүйцэт
1	Нүүрс	269.1	212.0	443.4
2	Зэсийн баяжмал	479.5	469.0	487.3
3	Бусад	99.1	125.4	116.3
	ДҮН	847.7	806.4	1,047.0
	Тогтворжуулалтын санд	297.4	97.4	137.7
	Ирээдүйн өв санд	357.7	460.9	588.6
	Тэнцвэржүүлсэн орлого	192.6	248.1	320.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.1.19 Энэ нь тайлант онд тооцсон зэсийн зах зээлийн болон тэнцвэржүүлсэн үнийн зөрүү өмнөх оноос бага байсантай холбоотой байна.

2.1.20 АМНАТ-аас Ирээдүйн өв санд төвлөрүүлсэн орлого 127.7 тэрбум, өмнөх оноос 230.9 тэрбум төгрөгөөр тус тус өсчээ.

2.1.21 Уул уурхайн голлох эрдэст бүтээгдэхүүн зэсийн баяжмалын экспорт 2018 онд 1,436.7 мян.тн-д хүрч, төлөвлөснөөс 70.7 мян.тн-оор илүү, өмнөх оноос 10.5 мян.тн-оор дутуу биелсэн бол нүүрсний экспорт 36,265.1 мян.тн-д хүрч, төлөвлөснөөс 8,265.1 мян.тн, өмнөх оноос 2,864.6 мян.тн-оор тус тус өссөн байна.

Хүснэгт 6 Уул уурхайн компаниудын экспортын биет хэмжээ, нийт төлсөн татвар

Бүтээгдэхүүн	2017 он		2018 он		Нийт төлсөн татвар /тбт/
	Биет хэмжээ мян.тн	Төлсөн татвар /тбт/	Биет хэмжээ /мян.тн/		
			Төлөв	Гүйцэт	
Зэсийн баяжмал	1,447.2	887.5	1,366.0	1,436.7	999.0
“Оюу Толгой” ХХК	795.4	346.0	764.8	796.8	391.4
“Эрдэнэт үйлдвэр” ХХК	651.8	527.7	601.2	639.9	601.4
Бусад		13.8			6.2
Нүүрс	33,400.5	693.0	28,000.0	36,265.1	998.0



“Эрдэнэс Тавантолгой” ХК	8,389.9	226.4	8,688.6	11,666.2	409.5
“Монголын алт (МАК)” ХХК	4,710.1	102.4	4,000.0	7,092.1	180.5
“Энержи ресурс” ХХК	4,440.8	73.0	3,900.0	4,221.5	117.0
“Саусгоби сэндс” ХХК	4,587.1	46.0	3,700.0	2,780.4	24.9
Бусад	11,272.6	245.2	7,711.4	10,504.9	266.1

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.1.22 Хүснэгтээс үзвэл, Зэсийн баяжмалын экспортын 55.5 хувийг “Оюу толгой” ХХК, 44.5 хувийг “Эрдэнэт үйлдвэр” ХХК тус тус эзэлж байна. Нүүрсний экспортын 32.2 хувийг “Эрдэнэс Тавантолгой” ХК, 19.6 хувийг “Монголын алт (МАК)” ХХК, 11.6 хувийг “Энержи ресурс” ХХК, 7.7 хувийг “Саусгоби сэндс” ХХК, 28.9 хувийг уул уурхайн бусад компаниудын экспорт тус тус эзэлж байна.

2.1.23 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн татварын бус орлогыг 1,047.8 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 1,117.3 тэрбум төгрөгт хүрч, 6.6 хувиар буюу 69.5 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 157.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.

2.1.24 Татварын бус орлого нийт дүнгээрээ биелсэн боловч зарим нэр төрлийн орлого дутуу төвлөрчээ. Тухайлбал, Тусламжийн орлого 21.5 тэрбум, төсөвт байгууллагын өөрийн орлого 16.8 тэрбум, газрын тосны орлого 0.9 тэрбум, хөрөнгийн орлого 0.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу биелсэн байна.

2.1.25 Дээрх үзүүлэлтэд дараах хүчин зүйлс нөлөөлжээ. Үүнд,

- Газрын тосны экспортын биет хэмжээ төлөвлөсөн хэмжээнээс 23.6 хувиар буурсан;
- БНХАУ, БНСУ, Япон, Кувейт улсын буцалтгүй тусламжаар хэрэгжиж буй төсөл, арга хэмжээний тоног төхөөрөмж, барилга байгууламж болон зөвлөх үйлчилгээгээр хэрэгжсэн нийт 11.9 тэрбум төгрөгийг санхүүжүүлэгчээс гүйцэтгэгчид шууд шилжүүлсэн, 0.5 тэрбум төгрөгийн санхүүжилтийг нэмэлт төсвөөр тайлагнаж, төсвийн орлогын дүнд оруулан тооцоогүй;
- Орон нутгийн төсөвт байгууллагуудын өөрийн орлого 16.8 тэрбум төгрөгөөр тасарсан;
- Тайлант онд хэрэгжүүлэхээр тооцсон зарим хөрөнгийн дуудлага худалдаа хэрэгжээгүй байна.

2.2 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл

2.2.1 Монгол Улсын нэгдсэн төсвийн 2018 оны ТХМ-ээр нийт зарлагын дээд хэмжээг 9,651.5 тэрбум төгрөгөөр баталсан байна.

2.2.2 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлангаарх нийт зарлага ба цэвэр зээлийн төлөвлөгөө ТХМ-ээр баталснаас 383.6 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь орон нутгийн ИТХ-аас эцэслэн баталсан төсвөөр Сангийн яамны хянасан суурь зарлагыг нэмэгдүүлсэнтэй холбоотой байна.

2.2.3 Засгийн газрын 2017 оны 188 дугаар тогтоолоор улсын төсвийн хязгаарыг 7,419.9 тэрбум, НДС-ийн төсвийг 2,027.8 тэрбум төгрөгөөр баталсан ба Сангийн яам орон нутгийн төсвийг 2,383.8 тэрбум төгрөгөөр хянасан байна.

Хүснэгт 7 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн зарлагын бүтэц (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	Жилийн хязгаар	2018 оны			
		УИХ-д өргөн барьсан	УИХ-аар батлагдсан	Зөрүү	Хувь
1	2	3	4	5=3-2	6=3/2
НЭГДСЭН ТӨСӨВ*		9,651.8	9,651.5		
Улсын төсөв	7,419.9	7,691.1	7,710.8	271.2	103.7
Орон нутгийн төсөв ⁴	2,383.8	2,559.3	2,539.4	175.5	107.4
Нийгмийн даатгалын сангийн төсөв	2,027.8	1,808.3	1,808.3	-219.5	89.2
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв		341.3	341.3		

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

/*Цэвэр дүнгээр/

⁴ Сангийн яамны хянасан дүн



2.2.4 Хүснэгтээс үзвэл, Сангийн яам Монгол Улсын 2018 оны төсвийн төсөлд өгсөн ТЕЗ-дын саналыг хянаж, улсын төсвийг батлагдсан хязгаараас 271.2 тэрбум төгрөг буюу 3.7 хувиар нэмэгдүүлэн өргөн барьсан байна.

2.2.5 Сангийн яам улсын төсвийн 2018 оны урсгал зарлагыг төсвийн хязгаараас 94.4 тэрбум, хөрөнгийн зардлыг 248.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 71.8 тэрбум төгрөгөөр бууруулан УИХ-д өргөн барьсан байна.

2.2.6 Энэ нь төсвийн хязгаарт төрийн албан хаагчийг тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласны тэтгэмж болон бусад зардлыг тус тус тусгаагүйтэй холбоотой байна.

2.2.7 УИХ Монгол Улсын 2018 оны төсвийн урсгал зардлыг 3.7 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийг 57.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн хөрөнгийн зардлыг 41.0 тэрбум төгрөгөөр бууруулан 7,710.8 тэрбум төгрөгөөр баталжээ.

2.2.8 Сангийн яам орон нутгийн төсвийг анх хянасан дүнгээс 175.5 тэрбум төгрөг буюу 7.4 хувиар нэмэгдүүлэн тусгасан байна.

2.2.9 НДС-ийн төсвийн хязгаар 2,027.8 тэрбум төгрөгөөр батлагдсан боловч УИХ-ын 2017 оны 40 дүгээр тогтоолоор ЭМДҮЗ байгуулагдсанаар НДС-ийн төсөв 1,808.3 тэрбум, ЭМДС-ийн төсөв 341.3 тэрбум төгрөгөөр тус тус батлагдсан нь төсвийн хязгаараас 121.8 тэрбум төгрөгөөр нэмэгджээ.

2.2.10 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн зарлагыг Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөрт туссан арга хэмжээг үе шаттай хэрэгжүүлэх, хууль тогтоомж, төрийн үйлчилгээний хүртээмж, хамрах хүрээг нэмэгдүүлэхэд шаардагдах хөрөнгийг төсөвт тусгах чиглэлийг баримтлан 29 хөтөлбөр зориулалт, 294 дэд зориулалтаар төлөвлөжээ.

2.2.11 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсөвт 24 хөтөлбөр зориулалт, 119 дэд зориулалтын зардлыг 997.0 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлсэн бол боловсрол, соёл урлаг, батлан хамгаалах, нийгмийн болон бусад салбаруудад шинээр 32 дэд зориулалтын зардалд 164.3 тэрбум төгрөг тусгажээ.

2.2.12 Засгийн газрын дотоод болон гадаад шилжүүлэг, бусад шилжүүлгийг 300.4 тэрбум, нийгмийн халамжийн шилжүүлгийг 194.7 тэрбум, боловсрол, соёл урлаг, биеийн тамир, эрүүл мэндийн арга хэмжээг 124.3 тэрбум, хот суурин нийтийн үйлчилгээний арга хэмжээг 41.0 тэрбум, тэтгэврийн санд олгох татаасыг 39.6 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн байна.

2.2.13 Өмнөх онд хэрэгжүүлж байсан 21 хөтөлбөр зориулалтын зардлыг 528.8 тэрбум төгрөгөөр бууруулан төлөвлөсөн байна. Тухайлбал, Гадаад зээлээр хэрэгжүүлэх ажил, үйлчилгээг 42.7 тэрбум, төрийн байгууллага, ажилтны буруутай үйл ажиллагаанаас үүссэн хохирлын нөхөн төлбөрийг 12.6 тэрбум, зарим тэтгэмжийг 156.2 тэрбум, концессоор хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээг санхүүжүүлэх дүнг 94.9 тэрбум төгрөгөөр бууруулжээ.

2.2.14 Төсвийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2 дахь хэсэгт заасны дагуу "Төсвийн захирагчийн төсөвт зохицуулалт хийх" тухай Сангийн сайдын 2013 оны 73, 2018 оны 134 дүгээр тушаалаар батлагдсан журмыг тус тус баримтлан тайлант онд Сангийн сайдын 15 тушаалаар хуваарьт өөрчлөлт оруулж, төсвийн зардлын бүлэг хооронд 23.6 тэрбум төгрөгийн зохицуулалт хийсэн байна.

2.2.15 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл 9,317.2 тэрбум төгрөгт хүрч, 92.8 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 8 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн зарлагын бүтэц (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 оны		2018 оны			Өмнөх оны зөрүү
	гүйцэт	төлөв	гүйц	хувь	зөрүү	
1	2	3	4	5=4/3	6=4-3	7=4-2
Нэгдсэн төсөв*	9,017.3	10,035.1	9,317.2	92.8	-717.9	299.9
Улсын төсөв	7,139.6	7,710.8	7,181.9	93.1	-528.9	42.3
Орон нутгийн төсөв	2,437.1	2,935.3	2,762.7	94.1	-172.6	325.6
Нийгмийн даатгалын сангийн төсөв	1,890.9	1,808.3	1,814.6	100.3	6.3	-76.3
Эрүүл мэндийн даатгалын сангийн төсөв		341.3	311.7	91.3	-29.6	

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

/*Цэвэр дүнгээр/



2.2.16 Хүснэгтээс үзвэл, Улсын төсвийн зардал 93.1 хувийн, орон нутгийн төсвийн зардал 94.1 хувийн гүйцэтгэлтэй ба өмнөх оноос 42.3-325.6 тэрбум төгрөгөөр өссөн нь улсын болон орон нутгийн төсвийн урсгал зарлага 3.4-8.9 хувиар нэмэгдсэнтэй холбоотой байна.

2.2.17 ЭМДС-ийн төсвийн зардлыг төлөвлөснөөс 29.6 тэрбум төгрөгөөр дутуу, НДС-ийн төсвийн зардлыг 6.3 тэрбум төгрөгөөр хэтрүүлэн зарцуулсан байна.

Хүснэгт 9 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийн эдийн ангилал (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 оны		2018 оны			Өмнөх оны зөрүү
	Гүйцэт	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү	
1	2	3	4	5=4/3	6=4-3	7=4-2
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	9,017.3	10,035.1	9,317.2	92.8	-717.9	299.9
A Урсгал зарлага	7,043.2	7,688.0	7,350.3	95.6	-337.7	307.1
1 Бараа, үйлчилгээний зардал	3,141.4	3,468.5	3,327.5	95.9	-141.0	186.1
2 Хүү	1,156.5	1,150.7	1,046.4	90.9	-104.3	-110.1
3 Татаас ба урсгал шилжүүлэг	2,745.3	3,068.8	2,976.4	97.0	-92.4	231.1
Б Хөрөнгийн зардал	1,658.1	2,058.5	1,680.4	81.6	-378.1	22.3
В Эргэж төлөгдөх цэвэр зээл	316.0	288.6	286.5	99.3	-2.1	-29.5

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.2.18 Нэгдсэн төсвийн нийт зарлага ба цэвэр зээл төлөвлөснөөс 717.9 тэрбум төгрөгөөр дутуу гүйцэтгэлтэй байгаа нь урсгал зарлагыг 337.7 тэрбум, хөрөнгийн зардлыг 378.1 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардлыг 2.1 тэрбум төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна. Зарцуулагдаагүй нийт зарлага ба цэвэр зээлийн 73.7 хувийг улсын, 26.3 хувийг орон нутгийн болон ЭМДС-ийн төсөв тус тус эзэлж байна.

2.2.19 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн зардал 288.6 тэрбум төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 286.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар 7 ТЕЗ-д нийт 419.1 тэрбум төгрөгийн эргэн төлөгдөх зээлийг олгож, өмнөх онуудад олгосон зээлээс 132.6 тэрбум төгрөг төвлөрүүлжээ. Хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 10 Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл (тэрбум төгрөг)

ТЕЗ	Төсөл хөтөлбөрийн нэр	2018 оны		
		Төлөв	Гүйцэт	Зөрүү
Олгосон зээл, үүнээс		518.2	419.1	(99.1)
БСШУСС	Боловсролын зээлийн сан	96.8	32.5	(64.3)
Сангийн сайд	Олгох зээл /9 төсөл, арга хэмжээ/	201.7	186.9	(14.8)
ХНХС	"Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих" сан	22.9	15.9	(7.0)
ХХААХҮС	Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сан	97.8	96.3	(1.5)
	Тариалан эрхлэлтийг дэмжих сан	22.0	20.0	(2.0)
	Зах зээл бэлчээрийн удирдлагын хөгжил төсөл	1.8		(1.8)
	ХАА-н бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг дэмжих болон бусад төсөл	5.1		(5.1)
БХБС	Улаанбаатар хотын VII, XIV хорооллын орон сууцны хорооллын болон Зүүн, өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл	13.0	21.5	8.5
ЭХС	Олгох зээл /4 төсөл, арга хэмжээ/	21.9	21.5	(0.4)
ОНТЕЗ	15 аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид	35.2	24.5	(10.7)
Буцаан төлөгдсөн зээл, үүнээс		(229.6)	(132.6)	(97.0)
ХХААХҮС	ЖДҮХС, ТЭДС, МХС	(137.4)	(74.1)	(63.3)
ХЗДХС	Банк, хадгаламж зээлийн хоршооны ажлын алба	(20.6)	0	(20.6)
Сангийн сайд	ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төсөл	(71.6)	(58.5)	(13.1)
Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээлийн дүн		288.6	286.5	(2.1)

2.2.20 Тайлант онд Сангийн сайд, БСШУСС, ХХААХҮС, ХНХС, ЭХС болон орон нутгийн ТЕЗ-д нийт 348.2 тэрбум төгрөгийн зээлийг дамжуулан зээлдүүлэхээр төлөвлөснөөс 252.3 тэрбум төгрөгийн зээл олгож, 95.9 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй байгаа нь сургалтын зээл 64.3 тэрбум, 21 аймгийн ТЕЗ-д 10.7 тэрбум, ХЭДС 7.0 тэрбум, бусад төсөл, сангаас нийт 13.9 тэрбум төгрөгийн зээл олгоогүйтэй холбоотой байна.

2.2.21 Зарим төслүүдэд 26.4 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөгдсөнөөс гүйцэтгэлээр 39.2 тэрбум төгрөгт хүрч, 12.8 тэрбум төгрөгөөр хэтэрчээ. Тухайлбал, Зүүн өмнөд говийн хот, хил орчмын хотын хөгжил төсөл 5.6 тэрбум, Дарханы ДЦС-ын турбины шинэчлэлт төсөл 4.3 тэрбум, Орон сууцны хороолол, дэд бүтэц төсөл 2.9 тэрбум төгрөгөөр тус тус хэтэрсэн байна.



2.2.22 Гадаад эх үүсвэрээс санхүүжих нэр бүхий 6 төслийн хүрээнд нийт 16.0 тэрбум төгрөгийн зээл олгохоор төлөвлөсөн боловч гүйцэтгэл гараагүй байна.

2.2.23 Улсын төсөвт буцаан төвлөрүүлэх зээлийн төлөвлөгөөг 97.0 тэрбум төгрөгөөр буюу 42.2 хувиар дутуу биелүүлжээ. Тухайлбал,

- ХЗДХС-ТЕЗ: Хадгаламж зээлийн хоршоодод мөнгөө хадгалуулсан иргэдэд учирсан хохиролд төсвөөс олгосон зээлийн 20.6 тэрбум төгрөгийн авлага хуульд орсон өөрчлөлтийн улмаас эргэн төлөгдөх нь эрсдэлтэй байна.
- ХХААХҮС-ТЕЗ: ЗГҮЦ, дамжуулан зээлийн үлдэгдлээс ЖДҮХС 20.6 тэрбум, ТЭДС 23.4 тэрбум, МХС 19.3 тэрбум, нийт 63.3 төгрөгийг төвлөрүүлээгүй байна.
- Сангийн сайд-ТЕЗ:
 - ААНБ болон улс, орон нутгийн төсөвт байгууллагууд, төслүүд нийт 9.0 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс илүү төвлөрүүлсэн,
 - “4.0, 100.0 мянган айл” хөтөлбөрийн зээлийн 23.8 тэрбум төгрөг төвлөрүүлээгүй,
 - “Сайн малчин” хөтөлбөрт олгосон зээлийн эргэн төлөлт төлөвлөснөөс 1.7 тэрбум төгрөгөөр давсан байна.

2.3 Нэгдсэн төсвийн тэнцэл

2.3.1 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцлийг 2,630.3 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 27.9 тэрбум төгрөгийн ашигтай байна. Үүнийг төсвийн бүтцээр харуулбал:

Хүснэгт 11 Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн бүтэц (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 оны гүйцэт	2018 оны		
		Төлөв	Гүйцэт	Зөрүү
Нэгдсэн төсөв	(1,742.5)	(2,630.3)	27.9	2,658.2
Улсын төсөв	(1,966.0)	(2,503.4)	(353.5)	2,149.9
Орон нутгийн төсөв	0.1	(264.6)	6.6	271.2
НДС-ийн төсөв	223.4	103.0	275.5	172.5
ЭМДС-ийн төсөв	0	34.7	99.3	64.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.3.2 Хүснэгтээс үзвэл, Тайлант онд төлөвлөснөөс улсын болон орон нутгийн төсвийн алдагдал нийт 2,421.1 тэрбум төгрөгөөр буурч, ЭМД-ын болон НДС-ийн төсвийн тэнцлийн ашиг нийт 237.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр нэгдсэн төсвийн нийт алдагдал 2,658.2 тэрбум төгрөгөөр буурч, 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

2.3.3 Нэгдсэн төсвийн төлөвлөсөн алдагдлыг нөхөх зорилгоор тайлант онд 1,257.5 тэрбум төгрөгийн гадаад зээл, Ирээдүйн өв сангаас 100.0 тэрбум төгрөгийг тус тус авч, Ирээдүйн өв сангийн 408.7 тэрбум төгрөгийн авлагыг барагдуулж, өмч хувьчлалын орлогоос 9.4 тэрбум, нийт 1,775.6 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

2.3.4 Дээрх эх үүсвэрүүдээс ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 2,434.7 тэрбум, Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 280.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 911.4 тэрбум төгрөгөөр буурснаар нэгдсэн төсвийн нийт тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.

2.4 Монгол Улсын Засгийн газрын өр

Засгийн газрын өрийн /нэрлэсэн үнээрх/ нийт үлдэгдлийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулбал:

Хүснэгт 12 Засгийн газрын өрийн бүтэц (тэрбум төгрөг)

ЗАСГИЙН ГАЗРЫН ӨРИЙН БҮТЭЦ	2016.12.31	2017.12.31	2018.12.31	Өөрчлөлт 2017-2016	Өөрчлөлт 2018-2017	Дүнд эзлэх хувь
I. Засгийн газрын дотоод өр	6,464.9	4,230.1	2,370.7	-2,234.8	-1,859.4	10.6
1.1 Үнэт цаас	5,488.8	3,461.9	1,564.7	-2,026.9	-1,897.2	7.0
1.2 Өрийн бичиг/вексель	307.2	0.0	0.0	-307.2	0.0	0.0
1.3 Концесс	668.9	768.2	806.0	99.3	37.8	3.6
II. Засгийн газрын гадаад өр	15,815.3	18,521.5	19,996.3	2,706.2	1,474.8	89.4



2.1 Үнэт цаас	5,380.5	7,701.6	7,664.5	2,321.1	-37.1	34.2
2.2 Зээл	6,983.3	9,156.2	11,201.1	2,172.9	2,044.9	50.1
2.3 Засгийн газрын өрийн баталгаа	3,451.5	1,663.7	1,130.7	-1,787.8	-533.0	5.1
Засгийн газрын нийт өр (I+II)	22,280.2	22,751.6	22,367.0	471.4	-384.6	100.0
Засгийн газрын өр (ӨҮЦ)	18,861.0	20,212.1	18,955.9	1,351.1	-1,256.2	
Хуулиар тогтоосон өрийн хязгаар /хувиар/	88.0	85.0	80.0	-3.0	-5.0	
Засгийн газрын өр (ӨҮЦ)/ДНБ /хувиар/	78.8	74.4	58.9	-4.4	-15.5	

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.1 Хүснэгтээс үзвэл, Засгийн газрын 2018 оны өрийн үлдэгдлийн 89.4 хувийг гадаад, 10.6 хувийг дотоод өр эзэлж байна.

2.4.2 Засгийн газрын өрийн хэмжээ өмнөх оноос 384.6 тэрбум төгрөгөөр буурч, өрийн үлдэгдэлд гадаад зээл 50.1, гадаад үнэт цаас 34.2, дотоод үнэт цаас 7.0, Засгийн газрын өрийн баталгаа 5.1, төсвөөс эргэн төлөх концесс 3.6 хувийг тус тус эзэлж байна.

2.4.3 ОУВС-ийн хөтөлбөрийн хүрээнд хөнгөлөлттэй эх үүсвэрээр төсвийн алдагдлыг нөхөж, дотоодын өндөр хүүтэй ЗГҮЦ гаргалтыг зогсоосон нь Засгийн газрын өрийн (ӨҮЦ-ээр илэрхийлсэн) ДНБ-д эзлэх харьцааг бууруулахад нөлөөлснөөр өрийн бүтцэд гадаад өрийн эзлэх хувь өсч, дотоод өрийн эзлэх хувь буурсан байна.

2.4.4 ӨҮЦ-ээр илэрхийлсэн Засгийн газрын өрийн ДНБ-д харьцуулсан харьцаа 2017 онд 74.4 хувь байсан бол 2018 оны эцэст 58.9 хувь болж буурсан байна.

2.4.5 Засгийн газрын гадаад өрийн бүтэц нь гадаад зээл болон үнэт цаас, өрийн баталгаанаас бүрдэж байна.

Хүснэгт 13 Засгийн газрын гадаад өр (тэрбум төгрөг)

Гадаад өрийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь	Хүүгийн зардал
Гадаад зээл	9,156.2	1,490.3	280.2	834.8	11,201.1	56.0	170.9
Гадаад үнэт цаас	7,701.6	0.0	667.0	629.9	7,664.5	38.3	520.7
Өрийн баталгаа	1,663.7		663.5	130.5	1,130.7	5.7	74.0
Нийт дүн	18,521.5	1,490.3	1,610.7	1,595.2	19,996.3	100.0	765.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.6 Засгийн газрын гадаад валютаар илэрхийлэгдэж байгаа өрийн багцад ам.доллар 38.1 хувийг, зээлжих тусгай эрх 28.3 хувийг, иен 25.8 хувийг, евро 4.9 хувийг, бусад валют 2.9 хувийг тус тус эзэлж байгаа бөгөөд тайлант оны эцсийн үлдэгдлийн 1 ам.долларын ханшийг 2,642.92 төгрөгөөр тооцон илэрхийлсэн байна.

2.4.7 **Гадаад зээл** Засгийн газрын гадаад зээлийн үлдэгдэл өмнөх онд 9,156.2 тэрбум төгрөг байснаас тайлант онд 11,201.1 тэрбум төгрөгт хүрч, 2,044.9 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 14 Засгийн газрын гадаад зээл (тэрбум төгрөг)

Гадаад зээлийн ангилал	Эхний үлдэгдэл	Ашиглалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хувь
Төслийн зээл	6,396.5	1,015.4	216.9	559.4	7,754.4	69.2
Хөтөлбөрийн зээл	2,177.2	474.9	3.5	227.2	2,875.8	25.7
Арилжааны зээл	582.5		59.8	48.2	570.9	5.1
Нийт гадаад зээл	9,156.2	1,490.3	280.2	834.8	11,201.1	100.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.8 Монгол Улсын Засгийн газар гадаад орон, олон улсын банк, санхүүгийн 11 байгууллагаас 61 төсөлд 2018 онд 594.0 сая ам.доллар буюу 1,490.3 тэрбум төгрөгийн зээлийг авч ашигласан нь өмнөх оноос 739.3 тэрбум төгрөгөөр бага байна. Гадаад зээлийн ашиглалтын 30.8 хувийг хөтөлбөрийн, 69.2 хувийг төслийн зээл тус тус эзэлж байна.

2.4.9 Тайлант онд ОУВС-ийн “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээнд 613.3 сая ам.долларын хөтөлбөрийн зээл авахаар төлөвлөснөөс 190.0 сая ам.долларын зээлийн



ашиглалт гарч, 423.3 сая ам.долларын зээлийг ашиглаагүй нь дараах шалтгаантай холбоотой байна. Тухайлбал,

- ОУВС-ийн үнэлгээгээр Монголбанкнаас арилжааны банкуудад тавьсан өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх тухай шаардлагын хэрэгжилт хангалтгүй;
- Улаанбаатар хотын Олон улсын шинэ нисэх онгоцны буудлын менежментийн концессын гэрээг Япон Улсын талтай байгуулах хэлэлцээр эцэслээгүй зэргээс шалтгаалжээ.

2.4.10 Гадаад зээлийн үндсэн төлбөрт 280.2 тэрбум төгрөгийг төлж, 2018 оны жилийн эцсийн үлдэгдэл 4,238.2 сая ам.доллар буюу 11,201.1 тэрбум төгрөг байна.

2.4.11 Засгийн газрын 2018 оны гадаад зээлийн ашиглалт төсвийн гүйцэтгэлийн тайлангийн дүнгээс 233.0 тэрбум төгрөгөөр илүү байгаа нь мөнгөн бус хэлбэрээр хүлээн авсан хөрөнгийн бүртгэлтэй холбоотой байна.

2.4.12 **Гадаад үнэт цаас** Засгийн газрын гадаад үнэт цаас нь нийт өрийн багцын 34.2 хувийг эзэлж байгаа бөгөөд 2018 оны 12 дугаар сарын 31-нээрх нэрлэсэн үлдэгдэл 2,900.0 сая ам.доллар буюу 7,664.5 тэрбум төгрөг байна. Үнэт цаасны төрлөөр хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 15 Засгийн газрын гадаад үнэт цаас (тэрбум төгрөг)

Гадаад үнэт цаасны нэр	Гаргасан огноо	Хүүгийн түвшин хувиар	Зээлийн дүн сая/ам.дол	Эхний үлдэгдэл	Ашиг-лалт	Үндсэн төлбөр	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Хүүгийн төлбөр
Чингис бонд -12-0.5	12/5/2012	4.125	500.0	308.8		308.9	0.1		6.4
Чингис бонд -12-1.0	12/5/2012	5.125	1,000.0	2,427.1			215.8	2,642.9	129.3
Дим Сам бонд	6/30/2016	5.960	161.2	354.2		358.1	3.9		10.8
Мазаалай бонд -0.5	4/06/2017	10.875	500.0	1,213.6			107.9	1,321.5	134.8
Хуралдай бонд -0.6	3/09/2017	8.750	600.0	1,456.2			129.6	1,585.8	127.8
Гэрэгэ бонд-0.8	1/11/2017	5.625	800.0	1,941.7			172.6	2,114.3	111.6
НИЙТ ДҮН			3,173.1	7,701.6	0.0	667.0	629.9	7,664.5	520.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.13 Засгийн газраас 2012 онд гаргасан 500.0 сая ам.долларын Чингис бонд, 2015 онд гаргасан 1.0 тэрбум юанийн Дим Сам бондын үндсэн төлбөрт тайлант онд 273.1 сая ам.доллар буюу 667.0 тэрбум төгрөгийг төлсөн байна.

2.4.14 Гадаад бондын 2018 оны хүүгийн төлбөрт 210.1 сая ам.доллар буюу 520.7 тэрбум төгрөгийг төлсөн байна.

2.4.15 **Өрийн баталгаа** Засгийн газрын өрийн баталгаа тайлант оны эцэст 1,130.7 тэрбум төгрөгийн үлдэгдэл байгааг хүснэгтээр үзүүлбэл:

Хүснэгт 16 Засгийн газрын өрийн баталгаа (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Ашиг-лалт	Эргэн төлөлт	Ханшийн өөрчлөлт	Эцсийн үлдэгдэл	Эзлэх хувь
I. Засгийн газрын баталгаа						
Хөгжлийн банк	1,471.6		582.3	114.3	1,003.6	88.8
“МИАТ” ТӨХК	175.3		81.2	13.3	107.4	9.5
“Эрдэнэс Монгол” ХХК	16.8		0.0	2.9	19.7	1.7
Өрийн баталгааны дүн	1,663.7	0.0	663.5	130.5	1,130.7	100.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

2.4.16 Хөгжлийн банкны өрийн баталгааг авч үзвэл, тайлант онд Кредит Свисс банкны зээл 205.2 сая ам.доллар буюу 516.6 тэрбум төгрөг, БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл 27.0 сая ам.доллар буюу 65.7 тэрбум төгрөгийг тус тус хорогдуулж, ханшийн өөрчлөлтөөр 114.3 тэрбум төгрөгөөр өсч 1,003.6 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.Үүнд:

- Самурай бонд 30.0 тэрбум иен буюу 718.2 тэрбум,
- БНХАУ-ын Хөгжлийн банкны зээл 108.0 сая ам.доллар буюу 285.4 тэрбум төгрөг байна.

2.4.17 “Боинг” нисэх онгоц худалдан авсан “МИАТ” ТӨХК-ийн зээлд гаргасан өрийн баталгаанаас 2018 оны эргэн төлөлт 81.2 тэрбум төгрөгийг хорогдуулж, ханшийн өөрчлөлт



13.3 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн 40.6 сая ам.доллар буюу 107.4 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.18 “Эрдэнэс Монгол” ХХК-ийн үйл ажиллагааны эрсдэлийн болон санхүүгийн нэгдсэн удирдлагын тогтолцоог бэхжүүлэх зорилгоор хэрэгжүүлсэн АХБ-ны санхүүжилттэй 35.0 сая ам.долларын зээлд гаргасан Засгийн газрын өрийн баталгаа тайлант онд ханшийн өөрчлөлт 2.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 7.4 сая ам.доллар буюу 19.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.19 **Дотоод үнэт цаас** Тайлант оны эхэнд Засгийн газрын дотоод үнэт цаас 3,461.9 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байснаас эргэн төлбөрт 1,767.7 тэрбум, хөнгөлөлтийн төлбөрт 132.6 тэрбум, нийт 1,900.3 тэрбум төгрөгийг төлж, ханшийн зөрүү 3.1 тэрбум төгрөгөөр нэмэгдсэнээр тайлант оны эцэст 1,564.7 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна.

2.4.20 Тайлант онд Засгийн газрын дотоод үнэт цаас шинээр гаргаагүй байна.

2.4.21 Засгийн газрын дотоод үнэт цаасны үлдэгдлийн 68.1 хувийг улсын төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас, 8.0 хувийг Хүний хөгжил сангийн төсвийн алдагдлыг санхүүжүүлэх зориулалтаар гаргасан үнэт цаас, 23.9 хувийг сайн хувьцаа арга хэмжээг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаас эзэлж байна.

2.4.22 **Концесс** Өрийн удирдлагын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.7-д заасны дагуу төсвөөс эргэн төлөх концессын өр 2018 оны эхэнд 768.2 тэрбум төгрөг байснаас тайлант жилийн ашиглалт 187.9 тэрбум төгрөгөөр нэмэгдэж, 91.1 тэрбум төгрөгийн эргэн төлөлт хийгдэж 37.4 тэрбум төгрөгийн ханшийн алдагдал хүлээж, 96.4 тэрбум төгрөгийн концессын гэрээг цуцалж, 806.0 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Үүнээс, улсын төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй (барих-шилжүүлэх төрөл) 23 концессын гэрээний 803.5 тэрбум, орон нутгийн төсвөөс эргэн төлөх нөхцөлтэй 8 гэрээний 2.5 тэрбум төгрөг байна.



БҮЛЭГ 3. МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ ТӨСӨВ

3.1 Улсын төсвийн орлого

3.1.1 Монгол Улсын 2018 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 6,828.4 тэрбум төгрөгт хүрч, төлөвлөснөөс 31.1 хувиар буюу 1,621.0 тэрбум төгрөгөөр давж биелсэн нь өмнөх оны гүйцэтгэлээс 1,654.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 17 Улсын 2018 оны төсвийн орлогын бүтэц (тэрбум төгрөг)

ҮЗҮҮЛЭЛТ	2017 оны гүйцэт	2018 оны				Өмнөх оноос	
		Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	5,857.1	5,838.8	7,656.1	131.1	1,817.3	130.7	1,799.0
Тогтворжуулалтын сан	325.7	122.7	207.0	168.7	84.3	63.6	-118.7
Ирээдүйн өв сан	357.7	508.7	620.7	122.0	112.0	173.5	263.0
Нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн	5,173.7	5,207.4	6,828.4	131.1	1,621.0	132.0	1,654.7
Татварын орлого	3,987.2	3,835.0	5,430.6	141.6	1,595.6	136.2	1,443.4
Татварын бус орлого	1,186.5	1,372.4	1,397.8	101.9	25.4	117.8	211.3

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.1.2 Хүснэгтээс үзвэл, Монгол Улсын 2018 оны төсвийн нийт тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн 79.5 хувийг татварын, 20.5 хувийг татварын бус орлого бүрдүүлсэн байна.

3.1.3 Монгол Улсын төсвийн татварын орлого бүх нэр төрлөөр давж биелсэн бөгөөд 2018 онд төлөвлөснөөс нийт 41.6 хувиар буюу 1,595.6 тэрбум төгрөгөөр, өмнөх оноос 1,443.4 тэрбум төгрөгөөр нэмэгдсэн нь экспорт өмнөх оноос 13.1 хувиар, импорт 35.5 хувиар өссөн, ААНОАТ-ын орлого 84.7 хувиар, НӨАТ-ын орлого 44.7 хувиар тус тус давж биелсэнтэй холбоотой байна.

3.1.4 Татварын орлогын 40.4 хувийг НӨАТ, 23.5 хувийг орлогын албан татвар, 13.9 хувийг ОАТ, 12.6 хувийг гадаад үйл ажиллагааны орлого, 9.6 хувийг бусад татвар төлбөр, хураамжийн орлого тус тус бүрдүүлсэн байна.

3.1.5 ААНОАТ-ын орлогыг 2018 онд 691.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 84.7 хувь буюу 585.5 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 314.8 тэрбум төгрөгөөр өсөхөд татвар төлөгчдийн тайлангийн ирц өмнөх оноос 10.3 мянгаар, ногдолтой тайлан 4.0 мянгаар, НӨАТ-ын тайлан 1.9 мянгаар тус тус нэмэгдсэн нь голлон нөлөөлжээ.

Дүрслэл 2



Дүрслэл 3



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.1.6 НӨАТ-ын орлогыг 2018 онд 1,517.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 678.6 тэрбум төгрөг буюу 44.7 хувиар давж биелсэн, өмнөх оноос 577.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

3.1.7 НӨАТ-ын урамшууллын системийн үр дүнд бүртгэл, хяналтын тогтолцоо сайжирсан, мөн урамшууллын системийн цахим төлбөрийн баримтын тоо 2018 онд 289.2 саяд хүрч, өмнөх оны мөн үеэс 1.7 дахин өссөн зэрэг нь НӨАТ-ын орлого төлөвлөснөөс давж биелэхэд голлон нөлөөлжээ.



3.1.8 НӨАТ-ын урамшууллын цахим төлбөрийн баримтын сүүлийн 3 жилийн судалгааг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 18 НӨАТ-ын урамшууллын цахим төлбөрийн баримт

Үзүүлэлт/Оноор	2016	2017	2018
Шинээр НӨАТ төлөгчөөр бүртгүүлсэн тоо /мян/	2.3	2.9	3.8
Посс машин хэрэглэгчийн тоо /мян/	65.2	88.0	118.9
Хэвлэгдсэн баримтын тоо /сая/	192.7	272.7	435.1
Үүнээс: Баталгаажуулсан тоо /сая/	92.0	169.4	289.2
Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл			

3.1.9 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуульд заасны дагуу 2018 онд 20.0 хүртэлх хувийн буцаан олголтыг урамшуулал хэлбэрээр 121.5 тэрбум төгрөг олгохоор төлөвлөснөөс 790.9 мянган татвар төлөгч иргэнд 78.1 тэрбум төгрөгийг буцаан олгож, буцаан олголтын мөнгөн дүн 64.3 хувийн гүйцэтгэлтэй байна.

3.1.10 Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасны дагуу 2018 онд Монгол Улсад суугаа Элчин сайдын яам, консулын газар, олон улсын байгууллага, төлөөлөгчийн газар, төсөл хэрэгжүүлэгчид 3.9 тэрбум, НӨАТ төлөгчдөд 6.5 тэрбум, нийт 10.4 тэрбум төгрөгийг буцаан олгож, НӨАТ төлөгчөөс бусад татварын өрөнд 6.2 тэрбум төгрөгийг суутган тооцож, НӨАТ-ын сугалааны урамшууллаар 19.1 тэрбум төгрөгийг олгосон байна.

3.1.11 ОАТ-ын орлогыг 684.3 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 10.2 хувиар буюу 70.1 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 234.7 тэрбум төгрөгөөр өссөн боловч ОАТ-тай бараа бүтээгдэхүүнээс дотоодын тамхины ОАТ 7.2 тэрбум, автобензин, дизелийн түлшний ОАТ 81.9 тэрбум төгрөгөөр тус тус төлөвлөснөөс дутуу төвлөрчээ.

3.1.12 Монгол Улсын төсвийн татварын орлого давж биелэхэд дараах хүчин зүйлс нөлөөлсөн байна. Үүнд,

- Эдийн засгийн идэвхжил нэмэгдэж, бодит өсөлт 6.9 хувьд хүрсэн;
- ААНБ-уудад арилжааны банкуудаас олгосон зээлийн хэмжээ өмнөх оноос 190.0 орчим тэрбум төгрөгөөр нэмэгдэж, аж ахуйн нэгжийн үйл ажиллагаа идэвхжиж татварын орлого өссөн, импортын бараа өмнөх оноос 35.5 хувиар өсч, 14,498.7 тэрбум төгрөгт хүрсэн;
- ОАТ-тай суудлын автомашины импорт өнгөрсөн оноос 35.4 хувиар өссөн;
- Уул уурхайн голлох эрдэст бүтээгдэхүүн зэсийн баяжмалын экспорт төлөвлөснөөс 70.7 мян.тн-оор, жилийн дундаж үнэ тн тутамд 94.8 ам.доллараар өсч, 6,524.8 ам.долларт хүрсэн, нүүрсний экспорт төлөвлөснөөс 8.3 сая тн-оор, жилийн дундаж үнэ тн тутамд 23.6 ам.доллараар өсч, 77.3 ам.долларт хүрсэн;
- Татвар төлөгч байгууллагын ирүүлсэн тайлан өмнөх оноос 12.3 хувиар, ногдолтой тайлан 14.7 хувиар тус тус нэмэгдсэн байна.

3.1.13 Тайлант онд зарим гол нэр төрлийн татварын орлогыг тухайн үеийн зах зээлийн нөхцөл байдлаас шалтгаалан өмнөх оны гүйцэтгэлээс доогуур төлөвлөсөн нь орлого өндөр дүнгээр давж биелэхэд нөлөөлсөн байна. Тухайлбал,

- Орлогын албан татварыг 270.7 тэрбум төгрөгөөр доогуур төлөвлөсөн боловч өмнөх түвшнээс 314.8 тэрбум, төлөвлөснөөс 84.5 хувиар буюу 585.5 тэрбум төгрөгөөр;
- НӨАТ-ын орлогыг 101.2 тэрбум төгрөгөөр доогуур төлөвлөсөн боловч өмнөх түвшнээс 577.4 тэрбум, төлөвлөснөөс 44.7 хувиар буюу 678.6 тэрбум төгрөгөөр;
- АМНАТ-ийн орлогыг 41.4 тэрбум төгрөгөөр доогуур төлөвлөсөн боловч өмнөх түвшнээс 203.7 тэрбум, төлөвлөснөөс 30.4 хувиар буюу 245.1 тэрбум төгрөгөөр тус тус давсан байна.

3.1.14 Улсын төсвийн орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ давсан боловч зарим нэр төрлийн орлогын төлөвлөгөө дутуу биелжээ. Үүнд,

- Дотоодын тамхины ОАТ-ын орлогыг 36.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 19.9 хувь буюу 7.2 тэрбум төгрөгөөр;
- Автобензин дизелийн түлшний ОАТ-ын орлогыг 295.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 27.7 хувь буюу 81.9 тэрбум төгрөгөөр тус тус дутуу байна. Энэ нь Засгийн газрын 2018 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 26 дугаар тогтоолоор октаны хэмжээ 95-аас доош автобензины ОАТ-ын тн тутамд ногдуулах хувь хэмжээг тэглэсэнтэй холбоотой байна.

3.1.15 Монгол Улсын 2018 оны төсвийн татварын бус орлогыг 1,372.4 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 25.4 тэрбум төгрөгөөр буюу 1.9 хувиар давж биелэхэд хүү торгуулийн орлого 33.7 тэрбум төгрөгөөр, бусад орлого 33.7 тэрбум төгрөгөөр давсан нь голлон нөлөөлжээ.



3.1.16 Улсын төсвийн 2018 оны татварын бус орлогыг 147.1 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэх боломжийг алдсан байна. Үүнд,

- “Эрдэнэс Монгол” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангаарх 480.3 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 2018 онд улсын төсөвт төвлөрүүлэх 144.1 тэрбум төгрөгийн,
- “Монгол Улсын Хөгжлийн банк” ХХК-ийн 2017 оны санхүүгийн тайлангаарх 10.1 тэрбум төгрөгийн цэвэр ашгаас 2018 онд улсын төсөвт төвлөрүүлэх 3.0 тэрбум төгрөгийн ногдол ашгийн орлогыг ТӨБЗГ тус тус тооцож, 2018 оны тогтоол, шийдвэрт тусгаж, төвлөрүүлээгүй байна.

ТАТВАРЫН ЗАРЛАГА

3.1.17 Тайлант онд холбогдох хууль тогтоомжийн дагуу олгосон татварын хөнгөлөлт, чөлөөлөлт 857.5 тэрбум төгрөгт хүрсэн нь нийт татварын орлогын 10.4 хувьтай тэнцэж байна. Энэ нь өмнөх оноос 25.9 тэрбум төгрөгөөр буюу 2.9 хувиар буурсан байна.

3.1.18 Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд 0.8 мянга, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн хүрээнд 3.6 мянган хуулийн этгээд, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн хүрээнд давхардсан тоогоор 996.7 мянган иргэн нийт 496.8 тэрбум төгрөгийн татварын хөнгөлөлт, чөлөөлөлтөд тус тус хамрагдсан байна.

Хүснэгт 19 Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт (тэрбум төгрөг)

3.1.19 Гаалийн албан татварын тухай хууль, Гаалийн тариф, гаалийн албан татвараас чөлөөлөх тухай, Нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх тухай, Онцгой албан татварын тухай хуулиуд болон бусад холбогдох эрх зүйн актын хүрээнд 2018 онд нийт 1,050 иргэн, хуулийн этгээдийг 360.7 тэрбум төгрөгийн импортын барааны гааль, НӨАТ-ын болон ОАТ-аас чөлөөлсөн байна.

Татварын төрөл	2017	2018	Зөрүү	Бүтэц хувь
Татварын байгууллага	525.5	496.8	-28.7	57.9
ААНОАТ	273.2	240.6	-32.6	28.0
НӨАТ	126.8	113.3	-13.5	13.2
ХХОАТ	125.5	142.9	17.4	16.7
Гаалийн байгууллага	357.9	360.7	2.8	42.1
Гаалийн албан татвар	55.0	69.5	14.5	8.1
Онцгой албан татвар	195.7	130.0	-65.7	15.2
НӨАТ	107.2	161.2	54.0	18.8
Татварын зарлагын дүн	883.4	857.5	-25.9	100.0

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.1.20 Тайлант оны нийт татварын зарлагын 57.9 хувийг татварын, 42.1 хувийг гаалийн байгууллагын хөнгөлөлт, чөлөөлөлт тус тус эзэлж байна.

3.1.21 Өмнөх оноос Гаалийн албан татварын чөлөөлөлт 26.3 хувиар, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хуулийн чөлөөлөлт 17.3 хувиар, Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн чөлөөлөлт 13.8 хувиар тус тус нэмэгдэж, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хуулийн хөнгөлөлт, чөлөөлөлт 11.9 хувиар, Онцгой албан татварын тухай хуулийн чөлөөлөлт 33.5 хувиар тус тус буурсан байна.

3.2 Улсын төсвийн зарлага

3.2.1 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар төсвийн нийт зарлага ба цэвэр зээлийг өмнөх оны гүйцэтгэлээс 571.2 тэрбум төгрөг буюу 8.0 хувиар нэмэгдүүлэн 7,710.8 тэрбум төгрөгөөр төлөвлөсөн байна.

3.2.2 Зарим ТЕЗ-д төсвийн төслийн саналаа Сангийн яаманд ирүүлэхдээ Засгийн газрын 2017 оны 188 дугаар тогтоолоор баталсан төсвийн зарлагын хязгаарыг баримтлалгүйгээр давуулан төлөвлөсөн нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.1-д "жилийн төсвийн хязгаарт багтаан төсвийн төслийг боловсруулах" гэж заасантай нийцэхгүй байна.

3.2.3 Зарим ТЕЗ-дын төсвийг хязгаараас их хэмжээний хэлбэлзэлтэй баталсан байна. Тухайлбал, БСШУСС-ын төсөв 345.8 тэрбум, ХНХС-ын төсөв 195.7 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдэж, Сангийн сайдын төсөв 553.3 тэрбум төгрөгөөр буурсан байна.

3.2.4 Төсвийн хязгаараас хэтрүүлэн тооцсон зарим ТЕЗ-дын тайлбар, шинээр хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний болон нэг удаагийн шинж чанартай зардлын тооцоолол, үндэслэл хангалтгүй байна.

3.2.5 Сангийн сайдын 2015 оны 7 дугаар тушаалаар батлагдсан төсвийн зарлагыг төлөвлөхөд баримталж буй журмаар тогтоосон зарим зардлын эдийн засгийн ангиллыг хэрэглэх заавар



тодорхойгүйгээс тухайлсан зардал, хөтөлбөр, арга хэмжээ, төслүүдийн төсвийг зардлын эдийн засгийн ангиллын дагуу төлөвлөөгүй байна. Тухайлбал,

- Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардалд байр ашиглалтын үйлчилгээ 5.9 тэрбум, гэрээт ажиллагсдын зардал 1.5 тэрбум төгрөг;
- Боловсролын стандарт, сургалтын төлөвлөгөө хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний 4.2 тэрбум, Боловсролын салбарын мэдээллийн системийг хөгжүүлэх төслийн 1.2 тэрбум төгрөгийн зардлыг тус тус бусдаар гүйцэтгэх ажил үйлчилгээний зардалд төлөвлөсөн байна.

3.2.6 Зарим ТЕЗ-дын ирүүлсэн төсвийн саналд тусгасан хөтөлбөр, арга хэмжээний зардлыг холбогдох эрх зүйн актууд, бодит тоо мэдээ, нарийвчилсан тооцоо судалгаанд үндэслэн боловсруулаагүй, хяналтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайлбал,

- Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсрол, соёлын үйлчилгээ, нийтийн биеийн тамирын ТЗШ-ийн зардлын төлөвлөлтийн тооцоо судалгаа хангалтгүй,
- Эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ 112.8 тэрбум,
- Хүүхдийн хөгжил хамгааллын үйлчилгээнд 6.1 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан бөгөөд холбогдох ТЕЗ-д тус тус дотоод аудит хийгээгүй байна.

3.2.7 Тайлант онд улсын төсвийн зарлага 7,181.9 тэрбум төгрөг буюу 93.1 хувийн гүйцэтгэлтэй гарч, төлөвлөснөөс 528.9 тэрбум төгрөгийн дутуу биелэлттэй байна.

Хүснэгт 20 Монгол Улсын 2018 оны төсвийн зарлагын эдийн засгийн ангилал (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 оны гүйцэт	2018 оны				Дүнд эзлэх хувь
		Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү	
А	1	3	4	5=4/3	6=4-3	7
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	7,139.6	7,710.8	7,181.9	93.1	-528.9	100.0
А. Урсгал зарлага	5,524.2	5,973.2	5,713.6	95.7	-259.6	79.6
Бараа, үйлчилгээний зардал	1,901.8	2,106.2	1,993.7	94.7	-112.5	27.8
Хүү	1,156.5	1,150.7	1,046.4	90.9	-104.3	14.6
Татаас ба урсгал шилжүүлэг	2,465.9	2,716.3	2,673.5	98.4	-42.8	37.2
Б. Хөрөнгийн зардал	1,322.4	1,484.2	1,206.4	81.3	-277.8	16.8
В. Эргэж төлөгдөх цэвэр зээл	293.0	253.4	261.9	103.4	8.5	3.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

3.2.8 Нийт зарлагын 79.6 хувийг урсгал зарлагад, 16.8 хувийг хөрөнгийн зардалд, 3.6 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлд зарцуулсан байна.

3.2.9 Тайлант онд урсгал зарлага 95.7 хувийн, хөрөнгийн зардал 81.3 хувийн, эргэж төлөгдөх цэвэр зээл 103.4 хувийн гүйцэтгэлтэй байна. Өмнөх оноос урсгал зарлага 189.4 тэрбум төгрөгөөр өсч, хөрөнгийн зардал 116.0 тэрбум, эргэж төлөгдөх цэвэр зээл 31.1 тэрбум төгрөгөөр тус тус буурсантай холбоотой байна.

3.2.10 Урсгал зарлагын өсөлтөд урсгал шилжүүлэг 156.5 тэрбум, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал 37.6 тэрбум, татаас 51.0 тэрбум төгрөгөөр тус тус өссөн нь голлон нөлөөлжээ.

3.2.11 Зарим төсөв захирагчид төсвийг зарцуулахдаа холбогдох эрх зүйн актыг баримтлаагүйгээс зохих шийдвэрийг гаргаагүй, зориулалтын дагуу зарцуулаагүй, ажлын гүйцэтгэлийг үндэслэж санхүүжилтийг олгоогүй зэрэг зөрчилтэй байна. Тухайлбал,

- Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сан - Орон нутаг, нийслэлд хэрэгжүүлсэн зорилтот төслийг Хөдөлмөр эрхлэлтийн зөвлөлөөр хэлэлцүүлээгүй, тэргүүлэх чиглэл, шалгуур үзүүлэлтийг хангаагүй төсөл хөтөлбөрт 2,115.0 сая төгрөгийн санхүүжилт олгосон.
- “Хүнс тэжээл, нийгмийн халамжийн нэмэлт санхүүжилт” төсөл 972.8 сая, “Хөдөлмөр эрхлэх ур чадварыг сайжруулах” төсөл 20.3 сая төгрөгийг тус тус зохих шийдвэргүйгээр зарцуулсан.
- Үндэсний брендийн бодлогын зөвлөлийн ажлын алба - Нэр бүхий 8 аж ахуйн нэгжтэй байгуулсан “Ажил гүйцэтгэх гэрээ”-нд заасан хугацаа дуусаагүй, ажлыг бүрэн гүйцэтгээгүй байхад 449.7 сая төгрөгийн санхүүжилтийг бүрэн олгосон.
- Боловсролын зээлийн сангийн санхүүжилтээр 2013 – 2018 онд Дэлхийн шилдэг их, дээд сургуулиудын бакалаврын хөтөлбөрт хамрагдсан 2 суралцагчийг 2018 онд дахин магистрын хөтөлбөрт хамруулан 32.0 мянган ам.долларын санхүүжилтийг олгосон.
- ГХС - Хилийн чанадад байгаа Монгол Улсын иргэдэд туслах сангийн хөрөнгөнөөс Сангийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлээгүй 61.3 сая төгрөгийг зарцуулсан.



- ШЕЗ-ийн ажлын алба 302.5 сая төгрөгийн зардлыг эдийн засгийн ангиллын дагуу бүртгээгүй зэрэг зөрчлүүд байна.

3.2.12 Тайлант онд улсын төсвийн цалингийн зардал 1,034.2 тэрбум төгрөг буюу 98.7 хувийн гүйцэтгэлтэй байна. Зарим ТЕЗ-д цалин, хөлс болон нэмэгдэл урамшууллын зардлыг зориулалт бусаар зарцуулсан, илүү тооцож олгосон, батлагдсан орон тоог хэтрүүлсэн байна. Тухайлбал,

- Зэвсэгт хүчний анги, салбарын санхүүгийн ажилтан цалингийн зардлаас нийт 445.3 сая, Дорноговь аймгийн Прокурорын газрын нягтлан бодогч 11.5 сая төгрөгийг тус тус ашиглан шамшигдуулсан;
- Хууль зүйн туслалцааны төвийн захирал тушаал гарган захирал, нягтлан бодогч нар 2018 оны ажлын үр дүнгээ 200.0 хувиар тооцон үр дүнгийн урамшуулал, илүү цагийн хөлс авсан;
- “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл батлагдсан орон тооноос 4 ажилтан илүү ажиллуулсан;
- Зарим төсвийн захирагч цалингийн зардлыг бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлаас олгосон байна.

3.2.13 Улсын төсвийн томилолт, зочны зардал 19.5 тэрбум төгрөгт хүрч, 89.7 хувийн гүйцэтгэлтэй байгаа нь өмнөх оноос 4.4 тэрбум төгрөг буюу 29.1 хувиар нэмэгдсэн байна. Зардлын өсөлтөд ЗГХЭГ, ГХС, БХС, Сангийн сайдын ЭАХБ-ууд, ЕТГ-ын томилолтын зардал нэмэгдсэн нь нөлөөлжээ.

3.2.14 Зарим төсвийн захирагч гадаад томилолтын зардлын төсөв батлуулаагүй, холбогдох тушаал шийдвэргүйгээр томилолтын зардлыг олгосон байна. Тухайлбал,

- СЗХ- томилолтын зардлаас тээвэр шатахууны зардалд 11.9 сая төгрөгийг шилжүүлсэн, томилолтын урьдчилгаанд 6.5 сая төгрөгийг олгосон боловч томилолтоор ажиллаагүй;
- “Биологийн олон янз байдлыг хамгаалах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох” төсөл гадаад томилолтын 43.4 сая төгрөгийн батлагдаагүй зардал гаргасан;
- “Мянганы сорилтын корпораци”-ийн Үндэсний ажлын албаны дарга ГХС-ын тушаал шийдвэргүй, томилолтын зардлын төсөв батлуулалгүйгээр 19.1 сая төгрөгийг зарцуулсан;

3.2.15 *Хүүгийн зардал*: Тайлант онд Засгийн газрын өрийн үйлчилгээний төлбөрт нийт 1,150.7 тэрбум төгрөгийг төлөвлөснөөс 1,046.4 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарсан байна. Үүнээс, гадаад өрийн хүүгийн төлбөрт 692.2 тэрбум, дотоод зээл, үнэт цаасны хүүгийн төлбөрт 354.2 тэрбум төгрөгийг тус тус төлжээ.

3.2.16 Гадаад зээлийн хүүгийн төлбөрт 170.9 тэрбум, гадаад үнэт цаасны хүүгийн төлбөрт 520.7 тэрбум, гэрээнд заасан бусад төлбөрийн үүрэг, хураамжид 0.6 тэрбум төгрөгийг тус тус төлсөн байна.

3.2.17 Тусгай зориулалтын болон улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүүгийн зардал, хөнгөлөлтийн төлбөрт нийт 326.7 тэрбум төгрөгийг төлжээ. Тухайлбал,

- “Орон сууц” хөтөлбөрт гаргасан үнэт цаасны хүүгийн зардал 0.2 тэрбум,
- “Сайн хөтөлбөр”-үүдийн үнэт цаасны хүүгийн зардал 3.8 тэрбум,
- Улсын төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 190.1 тэрбум, хөнгөлөлтийн төлбөр 132.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.2.18 Өмнөх онуудад Хүний хөгжил сан /хуучин нэрээр/-ийн төсвийн мөнгөн хөрөнгийн дутагдлыг санхүүжүүлэх зорилгоор гаргасан үнэт цаасны хүү 27.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

3.2.19 Зарим ТЕЗ-д хөтөлбөр, арга хэмжээний хүрсэн үр дүнг төсөвтэй уялдуулан тайлагнаагүй, төсвийн зарцуулалтын талаарх тайлбарыг бүрэн гаргаагүй, төсвийн зарлагын бодит хэмнэлтийг тооцоогүй байна.

3.2.20 Сангийн сайдын 2008 оны 352 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн гүйцэтгэлийн тайлан”, 2012 оны 76 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн гүйцэтгэлийн тохируулгын маягт” нь Сангийн сайдын тушаалаар баталсан эдийн засгийн ангилал, санхүүгийн тайлангийн Э-тайлан програмтай уялдаагүй байна.

3.3 Улсын төсвийн тэнцэл

3.3.1 Тайлант онд улсын төсвийн нийт тэнцлийг 2,503.4 тэрбум төгрөгийн алдагдалтай байхаар төлөвлөснөөс 353.5 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй гарч, 7.1 дахин буурсан байна.



3.3.2 Улсын төсвийн алдагдлыг нөхөх зорилгоор 2018 онд гадаад зээл 1,168.1 тэрбум, Ирээдүйн өв сангаас 100.0 тэрбум, Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалтаар 408.7 тэрбум, өмч хувьчлалаас 0.7 тэрбум, нийт 1,677.5 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

3.3.3 Үүнээс, ЗГҮЦ-ны эргэн төлөлтөд 2,434.7 тэрбум, Засгийн газрын гадаад зээлийн эргэн төлөлтөд 280.2 тэрбум төгрөгийг тус тус зарцуулж, улсын төсвийн харилцах болон хадгаламжийн дансдын үлдэгдэл 1,390.9 тэрбум төгрөгөөр буурснаар нийт тэнцэл 353.5 тэрбум төгрөгийн алдагдалтай гарсан байна.



БҮЛЭГ 4. ОРОН НУТГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ

4.1 Орон нутгийн төсвийн орлого

4.1.1 Орон нутгийн 2018 оны төсвийн орлогыг 2,670.7 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 3.7 хувь буюу 98.6 тэрбум төгрөгөөр давж, өмнөх оноос 332.1 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 21 Орон нутгийн 2018 оны төсвийн орлогын бүтэц (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 оны гүйцэт		2018 оны			
	Төлөв	Гүйцэт	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
Нийт орлого ба тусламжийн дүн	2,437.2	2,670.7	2,769.3	103.7	98.6	
Татварын орлого	1,006.6	1,103.1	1,158.8	105.0	55.7	
Татварын бус орлого	1,430.6	1,567.6	1,610.5	102.7	42.9	

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.2 Орон нутгийн төсвийн татварын орлого 55.7 тэрбум, татварын бус орлого 42.9 тэрбум төгрөгөөр тус тус давж биелсэн байна.

Дүрслэл 4

4.1.3 Тайлант онд Улсын төсвөөс орон нутгийн төсөвт санхүүгийн дэмжлэг 180.7 тэрбум, ОНХНС-ийн орлогын шилжүүлэг 88.5 тэрбум, тусгай зориулалтын шилжүүлэг 1,119.1 тэрбум нийт 1,388.3 тэрбум төгрөгийг олгосон бөгөөд орон нутгийн суурь орлого 1,381.0 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.



Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

Хүснэгт 22 Аймаг, нийслэлийн төсвийн 2018 оны орлогын төлөвлөгөө, гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Аймаг, нийслэл	Орлого				Аймаг, нийслэл	Орлого			
	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
Архангай	69.1	69.8	101.0	0.7	Сүхбаатар	53.0	50.8	95.8	- 2.2
Баян-Өлгий	79.2	78.4	99.0	- 0.8	Сэлэнгэ	75.6	77.0	101.8	1.4
Баянхонгор	71.9	70.9	98.6	- 1.0	Төв	72.1	76.3	105.8	4.2
Булган	56.1	58.4	104.1	2.3	Увс	69.2	70.5	101.9	1.3
Говь-Алтай	56.2	57.5	102.3	1.3	Ховд	66.5	68.9	103.6	2.4
Дорноговь	62.4	63.4	101.6	1.0	Хөвсгөл	94.9	96.4	101.6	1.5
Дорнод	57.7	59.2	102.6	1.5	Хэнтий	60.1	63.2	105.2	3.1
Дундговь	41.7	42.0	100.7	0.3	Дархан-Уул	60.4	61.8	102.3	1.4
Завхан	64.6	66.1	102.3	1.5	Улаанбаатар	1,204.6	1,251.6	103.9	47.0
Өвөрхангай	78.7	80.8	102.7	2.1	Орхон	83.2	94.0	113.0	10.8
Өмнөговь	179.4	197.6	110.1	18.2	Говь-Сүмбэр	14.1	14.7	104.3	0.6
					Нийт дүн	2,670.7	2,769.3	103.7	98.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.1.5 Төсвийн орлогын төлөвлөгөөг Сүхбаатар, Баянхонгор, Баян-Өлгий аймгууд 0.8-2.2 тэрбум төгрөгөөр тасалсан нь газрын тосны тусгай зөвшөөрөлтэй нэр бүхий 4 аж ахуйн нэгж Засгийн газартай байгуулсан бүтээгдэхүүн хуваах гэрээний дагуу төлөх төлбөрийг дутуу төлсөн, технологийн дэвшилтэй холбоотой аж ахуйн нэгж байгууллагуудын ашиглах усны хэмжээ багассан, мөн уул уурхайн үйл ажиллагаа эрхэлдэг зарим аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг зогсоосон, СХС-аас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй байгаа зэргээс шалтгаалсан байна.

4.2 Орон нутгийн төсвийн зарлага

4.2.1 Тайлант оны орон нутгийн төсвийн нийт зарлага 2,935.3 тэрбум төгрөгөөр батлагдсанаас 2,762.7 тэрбум төгрөг зарцуулж, 94.1 хувийн гүйцэтгэлтэй байна.

Хүснэгт 23 Орон нутгийн төсвийн зарлагын төлөвлөгөө, гүйцэтгэлийн эдийн засгийн ангилал (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 оны гүйцэт	Орон нутгийн 2018 оны төсвийн зарлага			
		Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	2,437.1	2,935.3	2,762.7	94.1	-172.6
А. Урсгал зарлага	2,078.3	2,325.8	2,264.2	97.4	-61.6
Бараа, ажил үйлчилгээний зардал	1,383.7	1,530.4	1,497.6	97.8	-32.8



Татаас ба урсгал шилжүүлэг	694.6	795.4	766.6	96.4	-28.8
Б. Хөрөнгийн зардал	335.7	574.3	474.0	82.5	-100.3
В. Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл	23.1	35.2	24.5	69.6	-10.7

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.2.2 Орон нутгийн төсвийн нийт зарлагын 82.0 хувийг урсгал зарлага, 17.1 хувийг хөрөнгийн зардал, 0.9 хувийг эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал тус тус эзэлж байна.

4.2.3 Орон нутгийн төсвийн нийт зарлага өмнөх оноос 325.6 тэрбум, урсгал зарлага 185.9 тэрбум, хөрөнгийн зардал 138.3 тэрбум, эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл 1.4 тэрбум төгрөгөөр өссөн байна.

4.2.4 Урсгал зарлага өмнөх оноос 185.9 тэрбум төгрөг буюу 8.9 хувиар өссөн зарим шалтгааныг тодруулбал:

- Орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлого өмнөх оноос 93.8 тэрбум төгрөгөөр нэмэгдэж 289.2 тэрбум төгрөгт хүрсэн;
- Засгийн газрын 2018 оны 264 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлсэн.

4.2.5 Хөрөнгийн зардлын 57.9 хувийг барилга байгууламж, 3.0 хувийг их засвар, 39.1 хувийг бусад хөрөнгийн зардал тус тус эзэлж байна.

4.2.6 Орон нутгийн ТЕЗ, түүний харьяа зарим байгууллагууд холбогдох хууль, эрх зүйн актыг бүрэн мөрдөөгүй, төсвийг үр ашигтай, зөв зохистой зарцуулаагүйгээс нийт 2.2 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн байна. Тухайлбал,

- Нийслэл 1,619.1 сая, Сэлэнгэ 153.5 сая, Сүхбаатар 141.0 сая, Орхон 97.0 сая, Төв 71.0 сая, Говьсүмбэр 70.0 сая, Хөвсгөл 61.5 сая, Хэнтий 34.1 сая төгрөгийн төсвийг үрэлгэн, зориулалт бусаар зарцуулсан байна.

Хүснэгт 24 Аймаг, нийслэлийн 2018 оны төсвийн зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Аймаг, нийслэл	Зарлага				Аймаг, нийслэл	Зарлага			
	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү		Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
Архангай	71.7	69.1	96.4	-2.6	Сүхбаатар	56.5	51.2	90.6	-5.3
Баян-Өлгий	79.4	78.1	98.4	-1.3	Сэлэнгэ	79.5	78.2	98.4	-1.3
Баянхонгор	73.9	69.5	94.0	-4.4	Төв	80.3	76.1	94.8	-4.2
Булган	60.2	57.1	94.9	-3.1	Увс	72.2	69.6	96.4	-2.6
Говь-Алтай	58.3	55.4	95.0	-2.9	Ховд	70.0	68.5	97.9	-1.5
Дорноговь	63.8	61.9	97.0	-1.9	Хөвсгөл	100.8	97.8	97.0	-3.0
Дорнод	62.2	60.0	96.5	-2.2	Хэнтий	66.1	62.6	94.7	-3.5
Дундговь	44.2	40.4	91.4	-3.8	Дархан-Уул	68.0	69.9	102.8	1.9
Завхан	67.1	65.8	98.1	-1.3	Улаанбаатар	1,350.7	1,282.4	94.9	-68.3
Өвөрхангай	81.0	79.2	97.8	-1.8	Орхон	90.4	88.4	97.8	-2.0
Өмнөговь	222.6	167.0	75.0	-55.6	Говьсүмбэр	16.4	14.5	88.4	-1.9
Нийт дүн						2,935.3	2,762.7	94.1	-172.6

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

4.2.7 Орон нутгийн төсвийн нийт зарлага 172.6 тэрбум төгрөгөөр дутуу зарцуулагдсан нь зарим аймаг, нийслэлийн томоохон хөрөнгө оруулалтын ажлын гүйцэтгэл хангалтгүй, СХС-ийн зээлийн эргэн төлөлт бүрэн төлөгдөөгүй зэргээс шалтгаалсан байна.

4.2.8 Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар орон нутгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 289.2 тэрбум төгрөгөөр баталсныг Нийслэл, Өмнөговь, Орхон, Дорноговь, Дархан-Уул аймгууд бүрэн төвлөрүүлсэн байна.

4.2.9 Тайлант онд аймаг нийслэлийн ИТХ-аар Засаг даргын нөөц санд нийт 18.1 тэрбум төгрөг төсөвлөгдсөнөөс 17.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Сангийн сайдын 2012 оны 239 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ын 2.3⁵-т заасны дагуу нөөцөд байлгавал зохих 30.0 хувиас Нийслэл 2.0 тэрбум, 19 аймаг 2.4 тэрбум, нийт 4.4 тэрбум төгрөгийг зарцуулжээ.

⁵ “Энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана”



4.3 Орон нутгийн төсвийн тэнцэл

4.3.1 Тайлант онд орон нутгийн төсвийн нийт тэнцлийг 264.6 тэрбум төгрөгийн алдагдалтайгаар төлөвлөснөөс гүйцэтгэлээр 6.6 тэрбум төгрөгийн ашигтай гарсан байна.

4.3.2 Орон нутгийн 2018 оны төсвийн тэнцлийн төлөвлөсөн алдагдлыг Засгийн газрын гадаад зээлээс 53.6 тэрбум, өмч хувьчлалын орлогоос 6.1 тэрбум, харилцах болон хадгаламжийн дансны үлдэгдлээс 204.9 тэрбум төгрөгөөр тус тус санхүүжүүлэхээр төлөвлөж, гүйцэтгэлээр 89.4 тэрбум төгрөгийн гадаад зээл авч ашиглан, өмч хувьчлалын орлогоос 8.7 тэрбум төгрөг оруулж, тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 104.7 тэрбум төгрөгөөр өссөн байна.

4.3.3 Тайлант онд орон нутгийн төсвийн нийт тэнцэл 6.6 тэрбум төгрөгийн ашигтай гарахад нийслэл болон нэр бүхий 5 аймаг нийт 42.6 тэрбум төгрөгийн алдагдалтай, мөн 16 аймаг нийт 49.2 тэрбум төгрөгийн ашигтай байгаа нь нөлөөлжээ.



БҮЛЭГ 5. НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ

5.1 Нийгмийн даатгалын сангийн төсвийн орлого

5.1.1 Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар НДС-ийн орлогыг 1,911.2 тэрбум төгрөгөөр төлөвлөснөөс 2,090.1 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, 9.4 хувиар буюу 178.9 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна. Орлогын төрлөөр харуулбал:

Хүснэгт 25 НДС-ийн төсвийн орлого (тэрбум төгрөг)

	Орлогын төрөл	2017	2018 он			
		оны гүйцэт	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	880.3	1,009.8	1,139.4	112.8	129.6
2	Тэтгэмжийн даатгал	112.7	113.9	128.6	112.9	14.7
3	ҮОМШӨ-ний даатгал	147.9	140.3	171.2	122.0	30.9
4	Ажилгүйдлийн даатгал	39.0	37.4	41.1	109.9	3.7
	Дүн	1,179.9	1,301.4	1,480.3	113.7	178.9
5	Улсын төсвөөс санхүүжих	570.2	609.8	609.8	100.0	0
	Нийт дүн	1,750.1	1,911.2	2,090.1	109.4	178.9

Эх сурвалж: НДС, Сангийн яамны мэдээлэл

5.1.2 Сангийн нийт орлого нэмэгдэхэд өмнөх оноос ажил олгогчийн тоо 2.3 мянга, даатгуулагчийн тоо 71.2 мянган хүнээр тус тус өссөн нь нөлөөлжээ.

5.1.3 Улсын төсвөөс НДС-д 1995 оноос өмнө тэтгэвэр тогтоолгосон иргэдийн тэтгэвэрт

227.8 тэрбум, цэргийн тэтгэвэрт 122.9 тэрбум, тэтгэврийн даатгалын сангийн алдагдлыг нөхөхөд 259.1 тэрбум, нийт 609.8 тэрбум төгрөгийг төлөвлөн санхүүжүүлжээ.

5.1.4 Хадгаламжийн хүүгийн орлого 56.7 тэрбум, харилцах дансны үлдэгдэлд бодогдсон хүүгийн орлого 15.6 тэрбум, бондын хүүгийн орлого 2.3 тэрбум, нийт 74.6 тэрбум төгрөгийн хүүгийн орлого төвлөрүүлжээ. Энэ нь өмнөх оноос 34.2 тэрбум төгрөгөөр буурсан бөгөөд ЭМДС-д хадгаламж 167.0 тэрбум, харилцах дансны мөнгөн хөрөнгө 277.4 тэрбум, бонд 31.2 тэрбум, нийт 475.6 тэрбум төгрөгийг шилжүүлсэнтэй холбоотой байна.

5.2 Нийгмийн даатгалын сангийн төсвийн зарлага

5.2.1 Нийгмийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар зарлагыг 1,808.3 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 1,814.6 тэрбум төгрөгийг зарцуулж, 6.3 тэрбум төгрөгөөр төсөв хэтрүүлэн зарцуулсан байна. Зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт 26 НДС-ийн төсвийн зарлага (тэрбум төгрөг)

	Ангилал	2017	2018 он			
		оны гүйцэт	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
1	Тэтгэврийн даатгал	1,417.4	1,619.6	1,619.3	100.0	-0.3
2	Тэтгэмжийн даатгал	100.2	102.4	112.1	55.7	9.7
3	ҮОМШӨ-ний даатгал	46.0	31.7	29.9	94.3	-1.8
4	Ажилгүйдлийн даатгал	35.1	35.5	34.4	97.2	-1.1
5	Үйл ажиллагааны урсгал зардал	21.4	19.1	18.9	99.0	-0.2
	Дүн	1,620.1	1,808.3	1,814.6	100.3	6.3

Эх сурвалж: НДС-ийн мэдээлэл

5.2.2 НДС-ийн төсөв хэтрэхэд тэтгэмжийн даатгалын сангийн төсөв 9.7 тэрбум төгрөгөөр хэтэрсэн нь нөлөөлжээ. Энэ нь Нийслэлийн төвийн дүүргүүдэд тэтгэмж авагчдын тоо 11.2 мянган хүнээр нэмэгдсэнээр Нийслэлийн тэтгэмжийн даатгалын сангийн зардал 6.8 тэрбум төгрөгөөр хэтрэсэнтэй холбоотой байна.

5.2.3 Тайлант онд үйл ажиллагааны зардалд 19.0 тэрбум төгрөг батлагдсанаас 18.9 тэрбум төгрөг буюу 99.5 хувийн гүйцэтгэлтэй гарч, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал хэмнэгдсэн байна.

5.3 Нийгмийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

5.3.1 НДС-ийн төсвийн тэнцлийг 2018 онд 103.0 тэрбум төгрөгийн ашигтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 275.5 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсчээ.



БҮЛЭГ 6. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН 2018 ОНЫ ТӨСӨВ

Эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн 14, 15¹ дүгээр зүйл, "Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөл байгуулах тухай" УИХ-ын 2017 оны 40 дүгээр тогтоол, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоол, "ЭМД-ын байгууллагын бүтэц, дүрэм батлах тухай" ЭМДҮЗ-ийн 2017 оны 03 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЭМДЕГ-ыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлагийн статустайгаар ЭМС-ын эрхлэх асуудлын хүрээнд шинээр зохион байгуулж, 2018 оны эхнээс ЭМД-ын үйлчилгээг бие даан гүйцэтгэж эхэлсэн байна.

6.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн орлого

6.1.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар ЭМДС-ийн орлогыг 376.0 тэрбум төгрөгөөр баталж, 411.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлж, 9.3 хувиар буюу 35.1 тэрбум төгрөгөөр давж биелсэн байна.

6.1.2 ЭМДС-ийн 2018 оны орлогын 68.0 хувийг ажил олгогч, даатгуулагчид, 4.0 хувийг сайн дурын даатгалд хамрагдагсад, 16.4 хувийг төр хариуцах иргэдийн тус тус төлсөн шимтгэл, 11.6 хувийг бусад орлого бүрдүүлсэн байна.

6.1.3 ЭМД-д 2,824.7 мянган даатгуулагч хамрагдаж, хамрагдалт 88.9 хувьтай буюу нийт хүн амын 11.1 хувь буюу 350.0 мянга гаруй иргэн ЭМД-д хамрагдаагүй байна.

6.2 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн зарлага

6.2.1 Эрүүл мэндийн даатгалын сангийн 2018 оны төсвийн тухай хуулиар зарлагыг 341.3 тэрбум төгрөгөөр баталснаас 311.7 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй байна.

6.2.2 Тайлант онд төрийн болон хувийн хэвшлийн 1,600 гаруй ЭМБ-тай гэрээ байгуулан, давхардсан тоогоор 7.3 сая даатгуулагчдын тусламж, үйлчилгээний зардалд 308.1 тэрбум төгрөгийг зарцуулсан байна. Зардлын гүйцэтгэлийг хүснэгтээр харуулбал,

Хүснэгт 27 ЭМДС-ийн төсвийн зарлага (тэрбум төгрөг)

Ангилал	2018 он			
	Төлөв	Гүйцэт	Хувь	Зөрүү
1 Төрийн өмчийн ЭМБ-дад олгох	214.5	213.2	99.4	-1.3
2 Хувийн эмнэлэг, эмийн санд олгох	122.5	94.9	77.5	-27.6
3 Үйл ажиллагааны урсгал зардал	4.0	3.4	85.0	-0.6
4 Бусад	0.3	0.2	66.7	-0.1
Дүн	341.3	311.7	91.3	-29.6
<i>Эх сурвалж: ЭМДС-ийн мэдээлэл</i>				

6.2.3 Хувийн эмнэлэг, эмийн санд олгох тусламж үйлчилгээний зардал 27.6 тэрбум төгрөгийн дутуу гүйцэтгэлтэй гарсан нь нийт зардлын гүйцэтгэлд нөлөөлжээ.

6.2.4 "Цахим жор" програм хангамжийг үйл ажиллагаанд нэвтрүүлснээр төлбөр тооцооны хяналт сайжирч, 9.7 тэрбум төгрөг

хэмнэгдсэн байна.

6.2.5 Хувийн хэвшлийн эмнэлэгт олгох санхүүжилтээс 13.2 тэрбум төгрөгийн зардлыг хэрэгжүүлээгүй байна. Үүнд:

- Өндөр өртөгт тусламж үйлчилгээ үзүүлэх хувийн хэвшлийн 11 эмнэлгийг сонгон шалгаруулах ажил саатсанаас 6.9 тэрбум,
- Урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг оношилгоо шинжилгээг 2018 оны 4 дүгээр улирлаас эхлэн гэрээ байгуулан хэрэгжүүлснээс 2.8 тэрбум,
- Өрх, сум, тосгоны эрүүл мэндийн төвөөс үзүүлэх зарим төрлийн тусламж үйлчилгээг 2018 оны 8 дугаар сарын 01-ний хэрэгжүүлж эхэлснээс 3.5 тэрбум төгрөг тус тус дутуу зарцуулагдсан байна.

6.2.6 Үйл ажиллагааны урсгал зардлыг 4.0 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 3.4 тэрбум төгрөгийг зарцуулж, 0.6 тэрбум төгрөг дутуу зарцуулсан байна.

6.2.7 УИХ-ын НББСШУ-ны Байнгын хорооны 2018 оны 18 дугаар тогтоолоор ЭМДҮЗ-ийн Ажлын албаны орон тоог 13, "Агентлаг байгуулах тухай" Засгийн газрын 2017 оны 344 дүгээр тогтоолоор ЭМДЕГ-ын орон тооны дээд хязгаарыг 55-аар баталсан байна.

6.2.8 Сангийн яамны хянасан төсвийн хуваариар нийт ажиллагсдын тоог 90 байхаар төлөвлөсөн нь эрх бүхий байгууллагаас тогтоосон орон тооноос 22-оор илүү байна.



6.2.9 ЭМДҮЗ-ийн 2018 оны 04 дүгээр тогтоолоор ЭМДЕГ-ын төрийн захиргааны албан хаагчдыг 90, гэрээт ажилтныг 49, нийт 152 орон тоог баталж, гүйцэтгэлээр 160 орон тоотой ажилласан нь Байнгын хороо, Засгийн газрын баталсан дээд хязгаараас 92-оор хэтэрчээ.

6.3 Эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн тэнцэл

6.3.1 ЭМДС-ийн төсвийн тэнцлийг 2018 онд 34.7 тэрбум төгрөгийн ашигтай төлөвлөснөөс гүйцэтгэлээр 99.3 тэрбум төгрөгийн ашигтай гарч, сангийн мөнгөн хөрөнгийн үлдэгдэл өсчээ.



БҮЛЭГ 7. НЭМЭЛТ ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

7.1 Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл 17.8 тэрбум, тайлант онд 312.6 тэрбум төгрөгийн нэмэлт төсвийн эх үүсвэр төвлөрсөн нь өмнөх оноос 4.7 хувиар буюу 14.9 тэрбум төгрөгөөр буурсан байна. Нийт эх үүсвэрийн 59.1 хувийг төсвөөс, 40.9 хувийг төсвийн бус эх үүсвэрээс бүрдүүлсэн байна.

7.2 Нэмэлт төсвийн санхүүжилтийн эх үүсвэр дараах нэр төрлийн орлогоос бүрджээ. Үүнд,

- Дээд шатны төсөв захирагчаас доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө 122.5 тэрбум төгрөг,
- Засгийн газрын болон Засаг даргын нөөц хөрөнгөнөөс 62.3 тэрбум төгрөг,
- Төсөвт байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 79.2 тэрбум төгрөг,
- Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив тусламж 48.6 тэрбум төгрөг байна.

7.3 Нэмэлт санхүүжилтийн дансанд зориулалтын бус дараах орлогыг төвлөрүүлэн зарцуулж, тайлагнасан байна. Үүнд,

- Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам нь техник хяналтын орлого, зарлага
- Зам тээврийн хөгжлийн яамны Замын сангийн орлого, зарлага
- ОБЕГ-ын Ахмадын сангийн орлого, зарлага

Хүснэгт 28 Нэмэлт төсвийн зарлагын гүйцэтгэл (тэрбум төгрөг)

Үзүүлэлт	2017 он	2018 он	Үүнээс	
			Улсын төсвийн	Орон нутгийн
Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн	322.2	314.8	226.3	88.5
Урсгал зарлага	307.8	297.2	217.5	79.7
Бараа, ажил үйлчилгээний зардал	256.6	268.2	197.0	71.2
Татаас, урсгал шилжүүлэг	51.2	29.0	20.5	8.5
Хөрөнгийн зардал	14.4	17.6	8.8	8.8

Эх сурвалж: Сангийн яамны мэдээлэл

7.4 Хүснэгтээс үзвэл, 2018 оны нэмэлт төсвийн зарлага 314.8 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оноос 2.3 хувиар буюу 7.4 тэрбум төгрөгөөр буурсан үзүүлэлттэй байна. Нэмэлт төсвийн нийт зарлагын 94.4 хувийг урсгал зарлагад, 5.6 хувийг хөрөнгийн зардалд тус тус зарцуулсан байна.

7.5 Нэмэлт төсвийн зарлагын 71.9 хувийг улсын төсвийн, 28.1 хувийг орон нутгийн төсвийн байгууллагуудын зарлага эзэлж байна.

7.6 Улсын төсвийн ерөнхийлөн захирагчдын нэмэлт төсвийн 24.7 хувийг БХС, 13.5 хувийг БСШУСС, 12.5 хувийг ЭМС, 9.1 хувийг Шадар сайд, 40.2 хувийг бусад ТЕЗ тус тус зарцуулсан байна.

7.7 Орон нутгийн нэмэлт төсвийн 31.8 хувийг Нийслэл, 8.6 хувийг Өмнөговь аймаг, 5.4 хувийг Өвөрхангай аймаг, 4.2 хувийг Увс аймаг, 4.0 хувийг Сэлэнгэ аймаг, 46.0 хувийг бусад аймаг тус тус зарцуулсан байна.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаар

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар Монгол Улсын Ерөнхий сайдад 3, Сангийн сайдад 5, Татварын ерөнхий газрын даргад 1, нийт 9 зөвлөмж өгсөн болно. Зөвлөмжийн биелэлтийг Сангийн сайдын 2019 оны 3 дугаар сарын 25-ны өдрийн 13-1/1619, Татварын ерөнхий газрын даргын 2018 оны 10 дугаар сарын 11-ний өдрийн 01/3399 дугаар албан бичгээр Үндэсний аудитын газарт ирүүлснийг хянахад зөвлөмжийн 2 нь бүрэн хэрэгжсэн, 3 нь дутуу хэрэгжсэн, 4 нь хэрэгжих шатандаа байна.



ДҮГНЭЛТ

Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна. Үүнд:

1. Макро түвшний судалгаа, зах зээлийн гадаад, дотоод хүчин зүйлсийн үндэслэлийг бодитой тооцоолж, тусгаагүйгээс Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулийг батлахдаа өмнө баталсан ТХМ-ийг өөрчилсөн байна.
2. Уул уурхайн голлох нэрийн бүтээгдэхүүний үнэ өссөн, татварын бүртгэл, мэдээллийн системийн хамрагдалт сайжирсан, татварын суурийг өргөжүүлсэн, Засгийн газрын авч хэрэгжүүлсэн бодлогын үр дүнд экспорт нэмэгдсэн зэрэг шалтгааны улмаас төсвийн татварын орлого төлөвлөснөөс бүх нэр төрлөөр давж биелжээ.
3. Монгол Улсын 2018 оны төсвийн тухай хуулиар батлагдсанаас ТӨБЗГ ногдол ашгийн төлөвлөгөөг 31.6 тэрбум төгрөгөөр дутуу тооцож тогтоол, шийдвэр гаргасан нь тухайн орлого тасрахад нөлөөлсөн, өмнөх онд ашигтай ажилласан төрийн өмчийн зарим компанийн ногдол ашгийг тооцож, төвлөрүүлээгүйгээс төсвийн орлогыг нэмэгдүүлэх боломжийг алдсан байна.
4. Төсвийн төлөвлөлт болон тайлагналтай холбоотой журам заавар, програм хангамжийн яялдаа хангалтгүй байгаа нь төсвийн зарцуулалтыг хянах боломжийг сулруулж байна.
5. Зарим ТЕЗ-дын дотоод хяналтын бүтэц, орон тоо, зохион байгуулалт сул байгаагаас хяналтыг бүрэн хэрэгжүүлээгүй, зөрчил давтагдахад хүргэж байна.
6. Улсын төсвийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн зардал төлөвлөснөөс 8.5 тэрбум төгрөг буюу 3.3 хувиар хэтэрсэн нь зарим ТЕЗ-д өмнө олгосон зээлийн эргэн төлөлтийг хуваарийн дагуу төвлөрүүлээгүйтэй холбоотой байна.
7. Төсвийн тогтворжилтыг хангаж, орлого төлөвлөсөн хэмжээнээс давж биелснээр нэгдсэн төсвийн тэнцэл 27.9 тэрбум төгрөгийн ашигтай гарчээ.
8. Засгийн газрын өрийн үлдэгдэл 2018 оны жилийн эцсийн байдлаар 22,367.0 тэрбум төгрөгт хүрч, ӨҮЦ-ээр илэрхийлснээр ДНБ /урьдчилан тооцсон/-д харьцуулсан харьцаа 58.9 хувьтай тэнцэж, өмнөх оноос 13.6 нэгж хувиар буурсан байна.
9. Аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц санд журмын дагуу нөөцөд байвал зохих үлдэгдлийг байршуулаагүй, зарцуулалтад тавих хяналт хангалтгүй байна.
10. Сум хөгжүүлэх сангаас олгосон зээлийн эргэн төлөлт хангалтгүй, хөрөнгө оруулалтын ажлууд он дамжин хэрэгжиж, гүйцэтгэлээр санхүүжилтийг олгосноос зардлын бодит бус хэмнэлт үүсчээ.
11. Нэмэлт төсвийн дансад зарим зориулалтын бус орлого төвлөрүүлэн зарцуулж, тайлагнасан нь нэмэлт төсвийн орлого, зарлагын дүн буруу илэрхийлэгдэх нөхцөлийг бий болгох эрсдэлтэй байна.



Монгол Улсын Их Хуралд толилуулах нь:

Засгийн газраас тайлагнасан Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайланд тусгасан нийт орлого ба тусламжийн 10,172.8 тэрбум, нийт зарлага ба цэвэр зээлийн 9,317.2 тэрбум төгрөгийн гүйцэтгэлийг аудитаар баталгаажууллаа.

Монгол Улсын 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитаар төсвийн тогтвортой байдлыг хангах хуулийн шаардлагыг бүрэн хэрэгжүүлэх талаар Монгол Улсын Ерөнхий сайдад өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүйгээс 2018 оны төсвийг боловсруулж батлахдаа Төсвийн хүрээний мэдэгдэлд өөрчлөлт оруулах асуудал давтагдсан байна.

Төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой ААНБ-уудын ногдол ашгийн орлогыг төсөвт бүрэн төвлөрүүлэх талаар ТӨБЗГ-ын даргад өгсөн албан шаардлагын хэрэгжилт хангалтгүйгээс Монгол Улсын 2018 оны төсөвт батлагдсан ногдол ашгийн орлогын төлөвлөгөө 32.4 тэрбум төгрөгөөр тасарчээ.

Иймд Төрийн аудитын байгууллагын аудитаар өгсөн зөвлөмж, албан шаардлагыг хэрэгжүүлэхээр холбогдох албан тушаалтны боловсруулсан төлөвлөгөө, түүний хэрэгжилт, үр дүнг УИХ-ын Төсвийн Байнгын хороогоор хэлэлцүүлэн төсвийн сахилга бат, хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой шийдвэр гаргуулах саналыг уламжилж байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. ТЕЗ-дын төсвийн төлөвлөлт, зарцуулалтын хариуцлагыг дээшлүүлэх талаарх эрх зүйн зохицуулалтыг шинэчилж, дотоод хяналт, дотоод аудитын үр нөлөөг сайжруулах;
2. Улсын төсвөөс олгосон зээлийн эргэн төлөлтийг барагдуулах талаар тодорхой шийдвэр гаргаж, үе шаттай ажил зохион байгуулах;
3. Төсвийн тухай хуулиар батлагдсан ногдол ашгийн төлөвлөгөөг дутуу тооцож тогтоол, шийдвэр гаргасан болон ашигтай ажилласан төрийн өмчит компаниудын ногдол ашгийг төсөвт төвлөрүүлэх чиглэлээр тодорхой ажил зохион байгуулаагүй албан тушаалтнуудтай хариуцлага тооцох;
4. Аймаг, нийслэлийн Засаг даргын нөөц сан, Сум хөгжүүлэх сангийн орлого бүрдүүлэлт, зарцуулалтад тавих хяналт, төсвийн сахилга хариуцлагыг сайжруулах;

Сангийн сайдад:

1. Төсвийн орлогыг бүрэн дайчлах, эх үүсвэрийг нэмэгдүүлэх, зардлын үр ашгийг сайжруулах чиглэлээр тооцооллыг хянаж төсөвт тусгах, орлого төвлөрүүлэгч байгууллагуудын ажлын уялдааг хангах;
2. Төсвийн төлөвлөлт болон хэрэгжилт, тайлагналын талаарх журам заавар, програм хангамжийн уялдааг хангах, шинэчлэн баталж мөрдүүлэх;
3. Засгийн газрын гадаад зээлийн хөрөнгийн төлөвлөлт, тайлагналын уялдааг хангах бодлого боловсруулан хэрэгжүүлэх;
4. Нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайланд холбогдох журамд зааснаас бусад дансдын орлого зарлагыг хамруулж нэгтгэн тайлагнахгүй байх;



Хавьчсан II I

МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ОРЛОГЫН ГҮЙЦЭТГЭЛ

/Тэрбум төгрөгөөр/

	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,036.2	10,172.8	5,838.8	7,656.1	2,670.7	2,769.3	376.0	411.1	1,911.2	2,090.1
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	122.8	207.0	122.8	207.0	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	508.7	620.7	508.7	620.7	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,404.7	9,345.1	5,207.3	6,828.4	2,670.7	2,769.3	376.0	411.1	1,911.2	2,090.1
1. Татварын орлого	6,356.9	8,227.8	3,835.0	5,430.7	1,103.1	1,158.8	376.0	411.1	1,301.4	1,480.3
1.1. Орлогын албан татвар	1,449.1	2,091.1	691.4	1,276.9	757.7	814.2	-	-	-	-
1.1.1. Хувь хүний орлогын албан татвар	757.7	814.2	-	-	757.7	814.2	-	-	-	-
1.1.2. ААНБ-ын орлогын албан татвар	691.4	1,276.9	691.4	1,276.9	-	-	-	-	-	-
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	1,418.8	1,638.3	-	-	-	-	376.0	411.1	1,301.4	1,480.3
1.3. Хөрөнгийн албан татвар	122.8	141.2	-	-	122.8	141.2	-	-	-	-
1.4. Нэмэгдсэн өртгийн албан татвар	1,517.3	2,195.9	1,517.3	2,195.9	-	-	-	-	-	-
1.5. Онцгой албан татвар	684.3	754.5	684.3	754.5	-	-	-	-	-	-
1.6. Тусгай зориулалтын орлого	12.1	13.1	12.1	13.1	-	-	-	-	-	-
1.7. Гадаад үйл ажиллагааны орлого	536.9	682.2	536.9	682.2	-	-	-	-	-	-
1.8. Бусад татвар (төлбөр, хураамж)	615.6	711.5	393.0	508.1	222.6	203.4	-	-	-	-
2. Татварын бус орлого	1,047.8	1,117.3	1,372.3	1,397.7	1,567.6	1,610.5	-	-	609.8	609.8
2.1. Нийтлэг татварын бус орлого	936.6	1,027.7	760.2	810.8	176.4	216.9	-	-	-	-
2.2. Хөрөнгийн орлого	1.2	1.1	-	-	1.2	1.1	-	-	-	-
2.3. Тусламжийн орлого	110.0	88.5	612.1	586.9	1,390.0	1,392.5	-	-	609.8	609.8



МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ

/Тэрбум төгрөгөөр/

	Нэгдсэн		Улсын		О Нутаг		ЭМДС		НДС	
	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,035.1	9,317.2	7,710.8	7,181.9	2,935.3	2,762.7	341.3	311.7	1,808.3	1,814.6
А. УРСГАЛ ЗАРЛАГА	7,688.0	7,350.3	5,973.2	5,713.5	2,325.8	2,264.2	341.3	311.7	1,808.3	1,814.6
1. Бараа, үйлчилгээний зардал	3,468.5	3,327.5	2,106.2	1,993.7	1,530.4	1,497.6	4.0	3.4	18.8	18.4
1.1. Цалин, хөлс	1,900.3	1,878.9	1,048.2	1,034.2	837.3	830.1	1.4	1.3	13.4	13.3
1.2. Нийгмийн даатгалын шимтгэл, хураамж	-	-	88.1	84.2	101.1	99.7	0.2	0.2	1.5	1.5
1.3. Бараа, үйлчилгээний бусад зардал	1,568.2	1,448.6	969.9	875.3	592.0	567.8	2.4	1.9	3.9	3.6
2. ХҮҮ	1,150.7	1,046.4	1,150.7	1,046.4	-	-	-	-	-	-
3. Татаас ба урсгал шилжүүлэг	3,068.8	2,976.4	2,716.3	2,673.4	795.4	766.6	337.3	308.3	1,789.5	1,796.2
3.1. Татаас	245.3	230.0	702.5	698.7	105.2	103.3	47.5	37.7	-	-
3.2. Урсгал шилжүүлэг	2,823.5	2,746.4	2,013.8	1,974.7	690.2	663.3	289.8	270.6	1,789.5	1,796.2
Б. ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	2,058.5	1,680.4	1,484.2	1,206.4	574.3	474.0	-	-	-	-
1. Барилга байгууламж	1,232.1	1,094.6	948.8	820.2	283.3	274.4	-	-	-	-
2. Их засвар	92.2	89.9	76.3	75.8	15.9	14.1	-	-	-	-
3. Хөрөнгийн бусад зардал	734.2	495.9	459.1	310.4	275.1	185.5	-	-	-	-
В. ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ЦЭВЭР ЗЭЭЛ	288.6	286.5	253.4	262.0	35.2	24.5	-	-	-	-
1. Эргэж төлөгдөх дотоод цэвэр зээл	176.9	179.6	145.9	162.9	31.0	16.7	-	-	-	-
2. Эргэж төлөгдөх гадаад цэвэр зээл	111.7	106.9	107.5	99.1	4.2	7.8	-	-	-	-



МОНГОЛ УЛСЫН 2018 ОНЫ НЭГДСЭН ТӨСВИЙН ТЭНЦЭЛ

/Тэрбум төгрөгөөр/

	Нэгдсэн			Улсын			О Нутаг			ЭМДС			НДС			
	Төл	Гүй	Төл	Төл	Гүй	Төл	Төл	Гүй	Төл	Төл	Гүй	Төл	Төл	Гүй	Төл	Гүй
НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	8,036.2	10,172.8	5,838.8	7,656.1	2,670.7	2,769.3	376.0	411.1	1,911.2	2,090.1						
ТОГТВОРЖУУЛАЛТЫН САН	122.8	207.0	122.8	207.0	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
ИРЭЭДҮЙН ӨВ САН	508.7	620.7	508.7	620.7	-	-	-	-	-	-	-	-	-	-	-	-
НИЙТ ТЭНЦВЭРЖҮҮЛСЭН ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ДҮН	7,404.7	9,345.1	5,207.3	6,828.4	2,670.7	2,769.3	376.0	411.1	1,911.2	2,090.1						
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	10,035.1	9,317.2	7,710.8	7,181.9	2,935.3	2,762.7	341.3	311.7	1,808.3	1,814.6						
ТЭНЦЭЛ : - Нийт	(2,630.4)	27.9	(2,503.5)	(353.5)	(264.6)	6.6	34.7	99.3	103.0	275.5						
АЛДАГДЛЫГ САНХҮҮЖҮҮЛСЭН ЭХ ҮҮСВЭР:	2,630.4	(27.9)	2,503.5	353.5	264.6	(6.6)	(34.7)	(99.3)	(103.0)	(275.5)						
1. Харилцах болон хадгаламжийн дансны цэвэр өөрчлөлт	204.9	911.4	137.7	1,390.9	204.9	(104.7)	(34.7)	(99.3)	(103.0)	(275.5)						
3. ЗГ-ын бонд	(422.6)	(2,434.7)	(422.6)	(2,434.7)	-	-	-	-	-	-						
3.1. Урт хугацаат	(422.6)	(2,434.7)	(422.6)	(2,434.7)	-	-	-	-	-	-						
3.1.1. Дотоод	256.7	(1,767.7)	256.7	(1,767.7)	-	-	-	-	-	-						
3.1.1.1. Шинээр гаргах	2,389.7	-	2,389.7	-	-	-	-	-	-	-						
3.1.1.2. Үндсэн төлбөр	(2,133.0)	(1,767.7)	(2,133.0)	(1,767.7)	-	-	-	-	-	-						
3.1.2. Гадаад	(679.3)	(667.0)	(679.3)	(667.0)	-	-	-	-	-	-						
3.1.2.1. Шинээр гаргах	1,000.8	-	1,000.8	-	-	-	-	-	-	-						
3.1.2.2. Үндсэн төлбөр	(1,680.1)	(667.0)	(1,680.1)	(667.0)	-	-	-	-	-	-						
3.2.1. Дотоод	-	-	-	-	-	-	-	-	-	-						
3.2.1.1. Шинээр гаргах	419.7	-	419.7	-	-	-	-	-	-	-						
3.2.1.2. Үндсэн төлбөр	(419.7)	-	(419.7)	-	-	-	-	-	-	-						
4. ЗГ-ын зээл	2,519.2	1,386.0	2,465.6	1,296.6	53.6	89.4	-	-	-	-						
4.1. Дотоод	408.7	408.7	408.7	408.7	-	-	-	-	-	-						
4.1.2. Авлага	408.7	408.7	408.7	408.7	-	-	-	-	-	-						
4.1.2.3. Ирээдүйн өв сангийн авлага барагдуулалт	408.7	408.7	408.7	408.7	-	-	-	-	-	-						
4.2. Гадаад	2,110.5	977.3	2,056.9	887.9	53.6	89.4	-	-	-	-						
4.2.1. Төслийн зээл	576.1	502.5	522.5	413.1	53.6	89.4	-	-	-	-						
4.2.1.1. Шинээр авах	835.9	782.6	782.3	693.2	53.6	89.4	-	-	-	-						
4.2.1.2. Үндсэн төлбөр	(259.8)	(280.1)	(259.8)	(280.1)	-	-	-	-	-	-						
4.2.2. Хөтөлбөр болон төслийн бус зээл	1,534.4	474.8	1,534.4	474.8	-	-	-	-	-	-						
4.2.2.1. Шинээр авах	1,534.4	474.8	1,534.4	474.8	-	-	-	-	-	-						
7. Ирээдүйн өв сангийн шилжүүлэг	100.0	100.0	100.0	100.0	-	-	-	-	-	-						
8. Тогтворжуулалтын сангийн хуримтлагдсан үлдэгдэл	122.7	-	122.7	-	-	-	-	-	-	-						
9. Өмч хувьчлал	106.1	9.4	100.0	0.7	6.1	8.7	-	-	-	-						



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2018 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/54

Улаанбаатар хот

「Аудитын тайланг баталгаажуулах тухай」

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5, 13.4.7, 15 дугаар зүйлийн 15.1.7, 19 дүгээр зүйлийн 19.3.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.10.2 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Монгол Улсын 2018 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан”-г хавсралтаар баталгаажуулсугай.

2. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2019 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Ерөнхий сайд, Сангийн сайд, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргад тус тус зөвлөсүгэй.

3. Аудитын тайланг Улсын Их Хурал, Засгийн газар, Сангийн яаманд тус тус хүргүүлж, тайланд тусгагдсан зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг тооцож ажиллахыг Санхүүгийн аудитын газар /Ц.Наранчимэг/-т үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



Д.ЗАНДАНБАТ